



Бэлтгэсэн
Профессор.Доктор.Хурие Марты





Бүгд Найрамдах Турк Улс Ерөнхийлөгчийн Тамгын Газар Турк Улсын Шашны Хэрэг Эрхлэх Газар

Хэвлэлийн дугаар: 2511

Сурах бичиг: 720

Хэвлэлийг Хариуцсан Эрлэгч: Жафер Таяяр ДОЯМАЗ

Хэвлэлийн Зохион Байгуулагч: Фатих КАРАЗЭЙБЕК

Бэлтгэсэн: Проф.Др Хурие МАРТЫ

Орчуулга: Нурболат ИЗАЙ

График Дизайн: Али ЧЫНКЫ

Хэвлэлийг Бэлтгэсэн: Угур АЛТУНТОП- Мэхмэт КАЯАБАШЫ

ХЭВЛЭЛ: TDV Yay. Mat. Tic. İşl.

+90 312 354 91 36

1. р хэвлэл • Анкара • 2024

ISBN: 978-625-435-678-0

2024-06-Y-0003-2511

Сертификат №: 46325

Бүтээлийг Хянан Шалгах Комиссын Шийдвэр: 29.02.2024/26

© Туркийн Шашны Хэрэг Эрхлэх Газар

Холбоо барих:

Гадаад Хэл болон Бусад Аялгууд

Хэвлэл Мэдээллийн Хэлтсийн Газар

Утас: +90 312 295 72 81 4Факс: +90 312 28 472 88

И-мэйл: yabancidiller@diyanet.gov.tr

Агуулга

Нэгдүгээр Бүлэг

Итгэл Сүсэг Бишрэлийн Үндсэн Ойлголтууд

Хүмүүн	11
Шашин	15
Ислам	17
Сүсэг бишрэл буюу итгэл үнэмшил (Иман)	19
Аллахад иман (итгэн сүсэглэх)	21
Мелек буюу сахиусан тэнгэрүүдэд иман (итгэн сүсэглэх)	25
Ариун Судруудад Иман (итгэн сүсэглэх)	29
Сүүлчийн ариун судар: Куран Карим	33
Гэгээн элч нарт иман (итгэн сүсэглэх)	35
Сүүлчийн Элч Гэгээн Мухаммед (с.а.у)	39
Ахирет буюу нөгөө ертөнцөд иман итгэн (сүсэглэх)	43
Хувь Тавиланд Иман (Итгэн сүсэглэх)	45

Хоёрдугаар бүлэг

Ибадет буюу Мөргөл Залбирлын Үндсэн

Зарчмууд

Мөргөл Залбирлын Үндсэн Ойлголтууд	51
Келиме-й шахадат	55
Ариун Цэвэр	57
Угаалга ба бүтэн биеийн угаалга	61

Намаз мөргөл.....	65
Мацаг	71
Зекет ба Садака (Өглөг)	75
Хаж мөргөл.....	79
Курбан.....	83
Дуга	87

Гуравдугаар Бүлэг

ХҮМҮҮЖИЛ ТӨЛӨВШЛИЙН ЗАРЧМУУД

Ислам, Сайн Сайхан Төлөвшил	
Ёс суртахууны Шашин.....	93
Ислам, Шударга Үнэний Шашин.....	97
Ислам, Эв Нэгдэл ба	
Энх Тайвны Шашин.....	101
Ислам, Шинжлэх Ухаан Ба	
Мэргэн Ухааны Шашин	107
Ислам, Бүх Үйл Хэрэгт Зөөлөн	
Хандахыг Айлддаг.....	111
Ислам, Хайр Энэрлийн Шашин.....	113
Мусульман, Хариуцлагын	
Ухамсрыг Эрхэмлэдэг.....	117
Мусульман, Гэр Бүлдээ Сайн	
Сайхнаар Ханддаг	121
Мусульман, Орчиндоо Ээлтэй.....	125
Мусульман, Хэзээ ч Дарамталдаггүй.....	129
Мусульман, Шударга ба Үнэн Үгтэй	133
Мусульман, Талархлаа Илэрхийлдэг Албат	135
Мусульман, Алдаа Гаргахдаа Уучлал Хүсдэг.....	139
Мусульман, Диваажинд	
Хүрэх Замыг Эрэлхийлдэг.....	143
Мусульман, Тамд Оруулах	
Замуудаас Хол Зогсдог.....	149

Өмнөх Үг

Ислам, тухайн хүнийг ямар нэгэн албадалгүйгээр өөрийн сонголт ба хүсэлтээр, чин сэтгэлээсээ холбогдон Аллах руу чиглэх, Түүний тушаал болон хоригийг ямар нэгэн болзолгүйгээр хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. Төгс нэгэн итгэл үнэмшил, зан үйл болон ёс суртахууны тогтолцоог бүрдүүлсэн Ислам шашин, хэ. Адамын хамтаар хүмүүн төрөлхтөнд хүрч эхэлсэн эшлэлүүдийн (вахи) сүүлийн ба дутагдалгүй хэлбэр бөгөөд энэ ертөнцийн төгсгөл хүртэл хүчинтэй байх юм.

Ислам шашны бүх зарчмууд нь, Аллахын бүтээсэн гайхамшигтай тэнцвэрт байдлыг болон хүмүүнийг хамгаалахын төлөө юм. Исламын зорилго нь, хүнийг өөртэй нь, (Рабб)Эзэнтэй нь, бусад хүмүүстэй болон байгаль дэлхий дээрх амьтай-амьгүй зүйлстэй эрүүл харилцаа үүсгэхэд нь хөтөч болдог. Ийнхүү хувь хүн болон нийгмийн энх тайван, дэлхий дээрх шударга ёс, энэрэл нигүүлсэл давамгайлах болно.

Ислам, Куран-Каримийн замналаар Сүүлчийн Гэгээн элч Мухаммедын (с.а.у) зүгээс хүн

төрөлхтөнд илгээгдсэн итгэл үнэмшил (иман), зан үйл болон ёс суртахууны зарчмуудтайгаа амьдралын бүхий л салбарт сайн сайханд хүргэх зам руу хөтөлдөг. Хүрээлэн буй амьдралын хамгийн тохиромжтой хэлбэрээр нь оюун ухаан болон зүрх сэтгэлээ ашиглан өөрийгөө болон бусад амьтадын амьдрах орчныг бүрдүүлэхийн замыг хүмүүнд сургадаг. Үүний тулд итгэл үнэмшлийн зарчмуудыг өөрийн болгох, энэ зарчмуудын хүрээнд шашны зан үйлийн ухамсрыг баримтлах ба сайн сайхан хүмүүжил болон ёс суртахуунаар өөрийгөө цэнэглэх хэрэгтэй. Учир нь итгэдэг буюу сүсэглэн биширдэг хүн (мумин), Исламын итгэл үнэмшлийн зарчмуудыг баримталж тэдгээрт итгэн, итгэснээ үг хэллэгээрээ илэрхийлэн түүнийгээ амьдралдаа тусган хэрэгжүүлэхийг хэлнэ. Итгэсэн хүн (мумин) итгэл үнэмшлээ хамгаалах ба хүчирхэгжүүлэхийн тулд шашны зан үйлээ тууштайгаар үргэлжлүүлж, түүнийхээ хажуугаар ёс суртахуун зөв хүмүүжлийн шаардлагын хүрээнд амьдрах хэрэгтэй. Хамгийн онцгой шинж чанаруудын нэг болох ёс суртахуун ба хүмүүжилд анхаарлаа хандуулдаг Ислам шашны гол зорилго нь, итгэл үнэмшилтэй ба итгэл үнэмшлийнхээ шаардлагын дагуу ёс суртахуун болон төлөвшилтэй хүмүүсээс бүрдсэн эрүүл нэгэн нийгэм болон энх тайван ертөнцийг бий болгох юм.

Бидний шашны ерөнхий итгэл үнэмшил нь (иман), зан үйл болон хүмүүжил төлөвшлийн зарчмуудыг, ойлгогдохуйц нэгэн хэлээр дэлгэрэнгүй агуулгатайгаар хүргэхийг зорьсон

энэхүү ном маань, Исламын зөв мэдээлэл болон эрүүл өнцгөөс нь ойлгуулахыг зорьсон бүтээл юм. Шашны Хэрэг Эрхлэх Газрын Агентлегийн зүгээс хэвлэн гаргасан Хадисуудаар Ислам, Исламын Үндсэн Ойлголтууд, Туркийн Дианет Сангийн (TDV) Исламын Нэвтэрхий толь болон Кураны Зам Тайлбар гэх мэт эх сурвалжуудад үндэслэн бэлтгэсэн энэхүү ном нь, Исламын итгэл үнэмшил сүсэг бишрэлийн системээр амьдралаа утга учиртай болгох, зан үйлийн утга учир ёс суртахуун хүмүүжлийн зарчмуудаар зөвхөн энэ ертөнцөд бус, нөгөө ертөнцөө бүтээхийг хүссэн уншигчдадаа гэрэл гэгээ авч ирэхийг хүсье.



——
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ИТГЭЛ СҮСЭГ
БИШРЭЛИЙН
ҮНДСЭН
ОЙЛГОЛТУУД
——

Хүмүүн



*Үнэндээ Бид хүмүүнийг хамгийн төгс сайхан
бүтээсэн юм.*

*Дараа нь Бид түүнийг адгийн адагт оруулсан.
Гагцхүү сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд үүнээс
өөр билээ. Тэдэнд барагдашгүй буян хишиг буй.”¹
(Куран Карим)*

Хүн төрөлхтний, энэ дэлхийн хамгийн хүндтэй бүтээл юм. Ухаалаг, хүчтэй, хүсэл тэмүүлэл болон хариуцлагын эзэн, ухамсартай нэгэн оршихуй бөгөөд энэ дэлхийн хүүхэн хараа нь юм. Газар болон тэнгэрийн цор ганц эзэн агуу Аллахын зүгээс гайхамшигтай төгс зохицлоор бүтээгдсэн. Аллах, хүмүүнд тэнцвэртэй болон хэм хэмжээтэй нэгэн бие, амь өгч буй амин сүнс (рух), зөв бурууг ялгаж танин мэдэх нэгэн ухаан болон амьдралаа утга учиртай болгох нэгэн зүрх сэтгэл хайрласан. Тийм учраас хүн төрөлхтөн, биемахбодь болон зүрх сэтгэлээрээ нэгэн цогц бүтэн юм.

1 Тийн, 95/4-6

Хүнийг оргүй зүйлээс бүтээж, түүнд төгс байдлыг өгсөн, хооллож, ундаалж, цатгаж, хамгаалж, бүх төрлийн сайн сайхныг өгсөн Аллах эзэн юм. Агуу Аллахын хүнээс хүсдэг зүйл нь түүнд итгэн сүсэглэх болон сайн сайхан үйлийг хийж бүтээх юм. Учир нь хүний оршихуйн үндэс нь, нэгэн албатын хувиар хариуцлагаа үүрэн энэ дэлхийд амар тайван байдлыг бий болгох юм.

Хүн төрөлхтөний түүхэн замнал нь анхны хүн Гэгээн Адам болон түүний эхнэр болох гэгээн Хаввагаар(Ева) эхэлсэн. Түүний дараагаар хүмүүс, нэг нэгэнтэйгээ танилцах болон сайн харилцаа үүсгэхийн тулд олон үндэстэнд хуваагдсан.

Хүн, бусад оршихуйн амьтдаас илүү шинж чанартай, онцгой хүч болон чадваруудад эзэн. Тэдгээрийн ачаар сайн сайхныг хүсэж түүнийг амьдралдаа хэрэгжүүлдэг боловч, муу муухайг хүсэж түүнийг дэлхий даяараа түгээх чадварт бас эзэн юм. Заримдаа тэвчээртэй, хичээнгүй, харамгүй сэтгэлтэй, найрсаг ба шударга зангаараа жаргалтай нэгэн ертөнцийг бий болгосон ч; зарим үедээ мэдлэг мэдээлэлгүй, хувиа хичээсэн, зөрүүд, хэт түрэмгий хандлагын улмаас өөрийнхөө гараар өөрийгөө ангал руу түлхдэг.

Гэсэн хэдий ч Агуу Аллах, хүнийг хэзээ ч ганцаарыг нь буян хишиггүй болон тусламжгүйгээр хөсөр хаяагүй. Түүнийг амьдралын шалгуурт нь тусалж дэмжин, элчнүүдээрээ болон судруудаараа дамжуулан

түүнд замыг нь зааж өгсөн. Бүтээсэн ба хайр энэрлээр хандсан хүмүүндээ сайн сайхныг, зөв бурууг сургадаг; муу муухайг болон буруу гэж юу болохыг ойлгуулдаг нэгэн эмх цэгцтэй дүрэм журмыг илгээсэн. Тиймээс хүнийг амьдралынх нь туршид хөтөч хийдэг нөгөө ертөнцөд (ахирет) аврал руу хүргэхэд нөлөөлдөг энэхүү дүрэм журам нь «шашин» юм.

Шашин



*“Эргэлзээгүй, Аллахын өмнө хүлээн
зөвшөөрөгдсөн шашин Ислам юм.”²*

(Куран Карим)

Шашин, Аллахын зүгээс элч нараараа дамжуулан хүмүүст илгээсэн тэнгэрлэг хуулиуд юм. Энэ хуулиуд нь үнэний цор ганц эх булаг нь бөгөөд хүмүүсийг өөрсдийнх нь сонголтоор энэ ертөнцөд болон нөгөө ертөнцөд аз жаргалд хүргэхийн тулд илгээгдсэн.

Шашин анхны хүнтэй хамт үүссэн ба энэ ертөнцийн төгсгөл хүртэл байсаар байх болно. Учир нь анхны хүн байсныхаа хамтаар хамгийн анхны гэгээн элч Адам ба Хамгийн Сүүлчийн гэгээн элч Мухаммед Мустафа (с.а.у) бөгөөд энэ ертөнцийн төгсгөл хүртэл түүнээс өөр элч ирэхгүй.

Хүнд зайлшгүй нэг шашны шаардлага тулгардаг. Учир нь хүн, өөрийг нь бүтээсэн Агуу Бүтээгчийг таньж мэдэх болон бүтээгдсэн

2 Али Имран, 3/19

шалтгаанаа мэдэхийг хүсдэг. Яагаад юуны төлөө бүтээгдсэн? Амьдарч буй энэ ертөнцийн оршихуйн шалтгаан юу вэ? Амьдралын зорилго ямар байх хэрэгтэй вэ? Зөв бурууг хэрхэн ялгаж таних вэ? Нас барсны дараа өөрийг нь юу хүлээж байна вэ? Гэх мэт зүйлүүдийг мэдэхийг хүсдэг.

Шашны зарчим болон дүрмүүдийг Агуу Аллах тодорхойлдог. Бидний Рабб эзэн энэ зарчим болон дүрмүүдийг элчнүүддээ эшлэлээр (вахи) илгээдэг. Эшлэл (вахи), Аллахын зүгээс элч нартаа илгээсэн огтхон ч эргэлзээгүй мэдлэг, тэнгэрлэг ариун мэдээлэл, өнө мөнхийн үнэнийг илтгэнэ. Элч нарын үүрэг нь, энэхүү үнэнийг ба шашны зарчмуудыг хүмүүст хүргэх юм.

Хүмүүсийн өөрсдийнх нь зохиосон нэгэн зарчим, өөрсдийн тогтоосон хууль болон систем буюу тогтолцоо нь огтхон ч шашны байр суурийг эзэлдэггүй. Мөн Аллахын зүгээс илгээгдсэн боловч хүмүүсийн зүгээс зарчмууд нь өөрчлөгдсөн шашин ч гэсэн «жинхэнэ шашин» гэгдэх чанараа алдсан болно.

Шашин, хүнд болон түүний мөн чанарт нь нийцсэн амьдралыг бий болгодог. Оюун ухаан болон зүрх сэтгэлээ сонсон өөрийгөө ба бусад оршихуйнуудыг ч гэсэн амьдрах нэгэн дэлхийг бүтээх замыг заадаг. Хүмүүсийн асуултандаа хариулт олж авдаг хамгийн зөв мэдлэгийн эх сурвалж нь шашин юм. Энэ ертөнцийн төгсгөл хүртэл ирж буцах бүх хүмүүст ба хүн төрөлхтөнд илээгдсэн, асуултайндаа хариулт, асуудалдаа арга зам олж авах агуу шашин бол Ислам юм.

Ислам



“Эдүгээ Би та нарын шашныг төгс болгож.

Та нарт буян хишгээ хайрлаж, Та нарт

ислам шашныг таалан соёрхов.”³

Куран-Карим

Ислам гэдэг үгний утга нь энх тайван, амар амгалан болон хүлээн зөвшөөрөх гэх мэт утгуудыг илэрхийлдэг. Ислам, хүний ямар нэгэн дарамтгүйгээр өөрийнхөө сонголт болон хүсэлтээр, чин зүрхнээсээ холбогдон Аллах руу чиглэн, Түүний тушаал болон хоригуудыг нь болзолгүйгээр хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. Шашны хувьд Исламыг хүлээн зөвшөөрсөн ба зарчмуудыг дагаж мөрддөг хүнийг «Мусульман» гэж нэрлэдэг.

Ислам, Агуу Аллахын зүгээс, Сүүлчийн Элч болох гэгээн Мухаммедаар (с.а.у) дамжуулан илгээгдсэн сүүлчийн шашин юм. Энэ ертөнцийн төгсгөл хүртэл хүчинтэй, гайхамшигтай нэгэн сүсэг бишрэл, зан үйл болон ёс суртахууны тогтолцоо юм. Учир нь Бидний Аллах эзэн,

3 Майда, 5/3.

Исламаас өмнө илгээсэн шашнууд хүмүүсийн гараар өөрчлөгдөн, тэнгэрлэг ариун зарчмуудыг дахин сануулахын тулд Ислам шашныг илгээсэн.

Исламын бусад шашнуудаас ялгаатай нь, бүх хүмүүст чиглэсэн ба энэ ертөнцийн төгсгөлийн өдөр хүртэл хүчинтэй. Ислам шашны элч нь гэгээн Мухаммед Мустафа (с.а.у), судар нь бол Куран Карим юм. Куран, Гэгээн Адамын хамт хүн төрөлхтөнд эхэлсэн эшлэлийн (вахи) сүүлийн бөгөөд дутуугүй хэлбэр нь юм. Үүнээс хойш Исламаас өөр шашин, гэгээн Мухаммедаас өөр нэгэн элч, Куран Каримын дараа өөр ямар нэгэн ариун судар илгээгдэхгүй.

Ислам шашны бүх зарчмууд нь, Аллахын бүтээсэн экологийн тэнцвэр нь хүнийг хамгаалахын төлөө юм. Исламын зорилго нь, хүнийг өөртэй нь, Рабб эзэнтэй нь ба бусад хүмүүстэй эрүүл харилцаа үүсгэхэд нь хөтөч болох юм. Ингэснээр хувь хүн болон нийгмийн тайван байдал хадгалагдаж, энэ дэлхийд шударга үнэн ба хайр энэрэл давамгайлах болно. Энэхүү зарчмуудыг гурван гол сэдэвт хуваан авч үздэг: Итгэл үнэмшил сүсэг бишрэл, зан үйл ба ёс суртахууны зарчмууд.

Сүсэг бишрэл буюу итгэл үнэмшил (Иман)



*Аллахын алдраар тангараглая, сүсэг бишрэл,
итгэл үнэмшилгүйгээр диваажинд орж чадахгүй.*

Нэг нэгнээ хайрлахгүйгээр үл сүсэглэсэн болно.⁴

(Гэгээн Мухаммед с.а.у)

Хэн нэгний Ислам шашинд орох нь, сүсэглэн биширч Аллах эзэндээ итгэснээр эхэлдэг. Сүсэг бишрэл (иман) гэдэг нь Аллахын оршихуйд нь ба цорын ганц, мелек буюу сахиусан тэнгэрүүдэд, илгээсэн судруудад, илгээгдсэн элчнүүдэд, энэ ертөнцийн төгсгөлийн өдөрт болон хувь тавиланд итгэхийг хэлдэг. Сүсэг бишрэлтэй хүн (мүмин) гэдэг бол энэ бүгдэд итгэсэн, итгэснээ үгээр хэлэн амьдралдаа хэрэгжүүлсэн хүмүүнийг хэлнэ.

Сүсэг бишрэлийн (иман) утга нь, амар амгалан болон айдас түгшүүргүй болохыг илэрхийлдэг. Сүсэглэн биширч итгэсэн хүн, Аллахад итгэн даатгаснаар бүх төрлийн айдас

4 Абу Давуд, Едеб, 130.

түгшүүрээс ангижирдаг. Амьдрал нь утга учиртай болох ба тайтгарал амар амгалан даган ирдэг. Өөртөө итгэх итгэл нь нэмэгдэж, бэрхшээлүүдийг сөрөх тэсвэр хатуужилтай болдог.

Иман буюу сүсэг бишрэл, хүнийг муу муухай үг болон үйлдлээс хол байлгадаг. Түүнийг буруу зам руу орохоос; төөрөгдөл болон гажуудсан нэгэн амьдралаар амьдрахаас хамгаалдаг. Ингэснээр хүнийг, гэр бүлийг нь, орчин тойронд нь, амьдарч байгаа хот болон улстаа дэлхий даяар сайн сайхныг түгээсэн, муу муухайгаас сэргийлсэн, шударга нэгэн хүн болгодог.

Иман (сүсэг бишрэл) нь зургаан үндсэн зарчимтай. Эдгээр нь; Аллахад итгэх, мелек буюу сахиусан тэнгэрүүдэд итгэх, ариун судруудад итгэх элчнүүдэд нь итгэх, энэ ертөнцийн төгсгөл болон хувь тавиланд итгэх юм.

Аллахад иман (итгэн сүсэглэх)



*«Хэн нэгэн чин зүрхнээсээ итгэн хүлээн
зөвшөөрч Аллахаас өөр бурхан үгүйд бас
Мухаммед Аллахын элч болохыг гэрчилбэл,
Аллах тэр хүнийг тамд оруулахгүй. »⁵
(Гэгээн Мухаммед(с.а.у))*

Аллахад итгэх итгэл сүсэг бишрэл нь, Исламын үндсэн зарчим юм. Агуу Аллах, дэлхий ертөнцийг оргүйгээс бий болгон бүтээж, атомоос эхлээд огторгуй хүртэлх бүхий л оршихуйн ертөнцийг бүтээсэн ба чиглүүлэн захирдаг. Хүнийг хамгийн түрүүнд ба бүхий л оршихуйг бүтээж, амьдруулж, үхүүлж дараа нь шинээр амилуулах тэр Аллах юм.

Аллах, цор ганц, түүнээс өөр бурхан тэнгэр үгүй. Тэр төрөөгүй, хэн нэгний зүгээс ч төрүүлэгдээгүй. Бүх зүйл Түүний хараат; Харин тэр бол юунаас ч хараат бус юм. Түүний адил ба төстэй юу ч үгүй. Тэр, өнгөрсөн ба ирээдүйн ямар ч оршихуйтай адилхан биш. Жинхэнэ хүч чадал, эрх мэдэл, ноёрхлын эзэн Аллах эзэн юм.

5 Бухари, Илим, 49.

Тэр амьд. Бүхий л амьд амьтан нэг өдөр үхнэ, Аллах бол хэзээ ч үхэшгүй мөнхийн үлддэг. Түүний оршихуйн эхлэл ба төгсгөл байхгүй.

Аллах, бүх зүйлийг харж байдаг, бүгдийг сонсдог ба хамгийн жижиг зүйлийг хүртэл мэдэж байдаг. Түүнд нууцлаг, түүнд хэцүү, өнгөрсөнд ба ирээдүйд Түүний мэдэл ба хүссэн зүйлээс гадна хэрэгжих зүйл юу ч байхгүй. Тэр хязгааргүй бүтээгч ба хүч чадлын эзэн юм. Уучлагч, зөв замд чиглүүлэгч, хамгаалагч, өршөөгч тэр юм. Албатууддаа буян хишгээ хүртээж, тусалж дэмжин, тэднийг хамгаалдаг тэр Аллах юм. Түүний хажуугаар ширк буюу түүнтэй бусад оршихуйг адилтгах, үгүйсгэх ба Аллахыг үгүйсгэхэд тууштай оролцсон нэгнийг шийтгэдэг юм.

Ислам тевхидийн шашин юм. Тевхид гэдэг нь, Аллахад итгэх ба Түүнтэй ямар ч зүйлийг адилтгахгүй байхыг хэлнэ. Сүсэглэн итгэсэн хүн, Аллахын оршихуй ба цор ганц, огтоос адил, төстэй, хамтрагч болон эн зэрэгцэх зүйл байхгүй гэдгийг чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрдөг. Түүнийг бүх нэршлүүдээр нь, шинж чанар ба хосгүй онцлогуудаар нь Түүнийг таньдаг ба Түүнтэй холбогддог. Энэхүү зөвшөөрлөө үг хэлээрээ илэрхийлэн тэрхүү замналаар амьдардаг. Чухамдаа хүмүүний үүрэг нь, өөрийг нь бүтээсэн, амьдруулж буй төрөл бүрийн буян хишгээр хангасан Рабб эзэндээ сүсэглэн итгэх нь юм.

Аллахад итгэх итгэл, бүх элч нарын нийтлэг урилга юм. Исламын урилгын анхны гол санаа

нь, тухайн хүний хийж чадах зүйлүүдийн хамгийн чухал нь юм. Үүний хажуугаар Агуу Рабб эзний албатууд дээрх эрх нь юм.

Аллахад итгэх нь; хамгийн ихээр Түүнийг хайрлах, Түүнд зохих хэлбэрээр нь хүндлэл үзүүлэхийг, бүхий л нөхцөл байдалд Түүнд найдан итгэхийг, зөвхөн түүнээс тусламж хүсэхийг сургадаг. Аллахад итгэсэн хүн, Түүний өөрийг нь хором мөч бүрд харж, сонсож, бүх үйл хөдлөлийг мэдэж байгаа ба нэгэн өдөр хариуцлага тооцоогоо өгөхийг мэдрэн амьдардаг. Итгэл үнэмшилдээ зүй зохистой нэгэн амьдралаар амьдрах ба бүхий л хүсэл тэмүүллийнхээ нэн түрүүнд Аллахын талархлыг урьтал болгодог. Тэрээр итгэл сүсэг бишрэлээрээ амар амгаланг олж, эргэн тойрныхоо хүмүүст амар амгаланг өгдөг.

Мелек буюу сахиусан тэнгэрүүдэд иман (итгэн сүсэглэх)



*«Хэн Аллахад, Түүний мэлэкүүд буюу сахиусан
тэнгэрүүдэд, ариун судруудад, гэгээн элч нарт
үл итгэж, ертөнцийн төгсгөлийн өдрийг
үгүйсгэвэл үнэнхүү төөрөгдөлд орно.»⁶
(Куран Карим)*

Хүн төрөлхтний түүх, хүчтэй бөгөөд үл үзэгдэх оршихуйн тухай сүсэг бишрэлээр дүүрэн байдаг. Сайн муугийн хэлцэл нь ихэвчлэн энэхүү оршихуйгаар төсөөлүүлэн ойлголт өгдөг. Гэвч өгсөн ойлголтуудын хэдэн хувь нь зөв бол? Зөвхөн үзэгдэх үл үзэгдэх ертөнцүүдийн Рабб эзэн болох Аллахын илгээсэн сүүлийн шашин энэ талаар үнэн зөв мэдээллийг өгөх болно. Чухамдаа Исламын шашны хувьд гэрлээс (нур) бүтээгдсэн сахиусан тэнгэрүүдийн оршихуйд итгэх нь, итгэл үнэмшлийн зарчмуудын нэг нь юм.

6 Ниса, 4/136.

Исламын шашны хувьд сахиусан тэнгэр нь; Алладын даалгасан төрөл бүрийн үүрэг даалгавруудыг гүйцэтгэдэг, Түүний тушаалуудыг нь эргэлзээгүй бүрэн итгэдэг, сайн сайхны бэлгэдэлтэй оршихуй юм. Сахиусан тэнгэрүүдийн хүйс болон идэж уух гэх мэт амьдрах онцлог шинж чанарууд нь байхгүй билээ. Кураны айлдваруудад далавчтай болох нь өгүүлэгддэг гэвч эмэгтэйчүүд болон шувуудаар төсөөлөх нь өрөөсгөл ойлголт юм. Үнэндээ Куран Судар, сахиусан тэнгэрүүдийг эмэгтэй хэмээн ойлголт өгөхийг эрс эсэргүүцэн тэднийг “Рахманы (Алладын) албатууд” хэмээн онцолдог.⁷

Сахиусан тэнгэрүүдийг өөр хоорондын нь онцлог ба үүргүүдээр нь ангилан хуваан авч үздэг. Алладын элч нартаа айлдвар (уахи) – ыг хүргэх үүрэгтэй Жебрайл, буян хишиг ба нигүүлслийн сахиусан тэнгэр бөгөөд байгалийн үзэгдлүүдийг хариуцдаг Микайл, үхлийн сахиусан тэнгэр Азрайл ба киямет буюу ертөнцийн төгсгөлийн мэдээлэгч болох Суурыг үлээх Исафил нар дөрвөн том сахиусан тэнгэрүүд юм. Түүнээс гадна дэлхий ертөнцийг удирдан чиглүүлдэг, хүн төрөлхтнийг хамгаалдаг, мөн хүмүүсийг сайн болон муу үйлдлийг нь тэмдэглэн хадгалдаг ба тэднийг Кабир буюу оршуулганд нь эхлээд асуулга авдаг, диваажин ба тамд үүрэг гүйцэтгэдэг бусад сахиусан тэнгэрүүд байдаг.

Сахиусан тэнгэрүүд бусад бүх амьд оршихуйн адилаар Агуу Алладын зүгээс бүтээгдсэн

7 Зухруф, 43/19.

оршихуй юм. Аллахын эсрэг хэзээ ч зогсдоггүй, зөвхөн Түүний зөвшөөрөл ба тушаалаар нь хөдөлдөг. Аллахын өөрсдөд нь илчилсэн зүйлээс илүүг мэддэггүй. Тиймээс ямар ч тохиолдолд бурхан, тэнгэр, удирдах хүч хэмээн хүлээн зөвшөөрөгдөхгүй.

Аллахад чин сэтгэлээсээ холбогдсон нэгэн Мусульман хүний хамгийн ерөнхий чанаруудын нэг нь, үл үзэгдэх буюу гайб-т (үл үзэгдэх ертөнц) итгэх явдал юм. Сахиусан тэнгэрүүдэд итгэх нь үүний нэг хэсэг юм.

Сахиусан тэнгэрүүдэд итгэдэг хүн, төрснөөс нас барах хүртэлх амьдралынхаа турш үргэлж хажууд нь байгаа, Аллахын зөвшөөрлөөр өөрийг нь харж хамгаалдаг, сайн сайхнаар дүүрэн оршихуйг мэдрэн аз жаргалтай болдог. Түүнийг сайн сайханд дуудан, өмнөөс нь ба араас нь очин муу муухайгаас хамгаалдаг, дэмждэг, уучлагдахын тулд залбирдаг сахиусан тэнгэрүүдийн ачаар итгэл найдвараар дүүрэн амьдардаг.

Ариун Судруудад Иман (итгэн сүсэглэх)



«Хүмүүс анх нэгдмэл нэг л ард түмэн байсан. (Нэг л итгэл үнэмшилтэй байв. Хожим тэдний зарим нь чин үнэнээр сүсэглэн, зарим нь үл наманчлан урвасан.) Дараа нь Аллах (мусульманчуудад диваажин бий хэмээн) баярлуулагч, (буруу номтнуудад там буйг) урьдчилан сануулагч гэгээн элчнүүдийг илгээсэн. Хүмүүсийн хоорондох үл ойлголцлыг шүүж шийдвэрлэх гэгээн элчүүдтэй хамт чин үнэн судруудыг илгээсэн.»⁸
(Куран-Карим)

Ариун судрууд, Агуу Аллахын үг ба хүмүүст хандаж хэлсэн үг юм. Түүний мөнхийн ба үүрдийн үгнүүд, тушаалууд, уахи буюу айлдваруудын бичигдсэн хэлбэр юм. Аллахын үгний бусад үгнээс үнэ цэнэ нь, Аллахын албатуудынхаа өмнөх үнэ цэнтэй адил билээ. Аллах, ном судар илгээн хамгийн үнэ цэнтэй оршихуй болох хүнийг харилцагчаар хүлээн зөвшөөрч, амьдралын шалгуурт түүнд замыг нь

8 Бакара, 2/213.

зааж өгсөн. Жинхэнэ үнэнтэй танилцахад нь, сайн мууг ялгахад нь боломж олгосон.

Түүхийн өмнөх үеүдэд зарим элчнүүдэд “сахифе, (хуудас)” нэртэй жижиг судрууд илгээгдсэн. Аллах эзний зүгээс гэгээн элч Адамд арван сахифе, гэгээн Шийтэд тавин сахифе, гэгээн Идрийст гучин сахифе, гэгээн Ибрахимд арван сахифе илгээсэн.

Дараа нь дөрвөн том судар илгээгдсэн. Гэгээн Мусад Таурат, гэгээн Давудад Забур, Гэгээн Исад (Есүс) Инжил ба хамгийн сүүлд нь гэгээн Мухаммед Мустафад (с.а.у) Куран Карим илгээгдсэн. Ертөнцийн төгсгөл хүртэл хүчинтэй ба хүмүүст чиглэсэн сүүлчийн ариун судар Куран юм.

Мусульман, бүх ариун судруудын Аллахын зүгээс илгээгдсэн, оршиж байгаад нь болон илгээгдсэн нь үнэн гэдэгт итгэдэг. Гэвч энэхүү тушаал нь, ариун судруудын гажуудалгүй ба өөрчлөгдөөгүй хэлбэрийг нь хамрах юм. Тиймээс хэн нэгэн Мусульман, сахифенүүдийн болон судруудын Аллахын зүгээс илгээгдсэн анхны жинхэнэ хэлбэрт нь итгэдэг. Куран Каримаас бусад судруудын Таурат, Забур ба Инжилийг (Библи) хүмүүсийн гараар өөрчлөгдсөн ба жинхэнэ хэлбэрээсээ холдсон гэдэгт нь итгэдэг.

Энэхүү итгэл үнэмшил нь, муминий айлдварын тухай үргэлж анхаарал ба болгоомжтой хандах шаардлагатай. Таурат эсвэл Инжил (библи)-ээс авсан нэгэн мэдээлэлтэй тулгарахдаа, энэхүү мэдээлэл нь зөв ба буруу

гэдгийн тодорхойлолгүйгээр хамгийн түрүүнд Куран сударт хандах хэрэгтэй. Энэ нь Куран судрын мэдээлэлтэй зөрчилдөхгүй, Исламын үндсэн зарчмуудын эсрэг биш бол энэхүү мэдээллийг үнэн зөв болохыг тодорхойлж болно. Гэсэн хэдий ч Куран судрын зарчмууд ба нийтлэг сургамж айлдваруудтай зөрчилдсөн нэгэн мэдээллийг Аллахаас ирсэн хэмээн батлан хэлэх боломжгүй юм.

Хүмүүс багахан хэмжээний ашиг хонжоо олохын тулд өөрсдөд нь илгээгдсэн судруудад өөрчлөлт (засвар) хийсэн. Өнгөрсөн цаг хугацаанд шашны лидерүүд өөрсдийн гараар бичсэн бичвэрээ Аллахын айлдвар мэт харуулж энгийн ард түмнийг хууран мэхэлсэн ба ариун судруудын цэвэр ариун байдлыг алдагдуулсан. Бичвэр ба агуулгын хувьд хамгийн бага ямар нэгэн өөрчлөлтөд оролгүй өнөөдрийг хүртэл ирсэн ба энэ ертөнцийн төгсгөл жинхэнэ төрхөө хамгаалан үлдэх цор ганц ном бол Куран судар юм.

Судруудад итгэх ба энэ хүрээнд Куран судрыг ариун нэгэн хөтчөө болгон хүлээн зөвшөөрөх, мэдээж Аллахын зүгээс илгээгдсэнд нь чин сэтгэлээсээ хандахын хэрээр, түүний доторх зарчмуудын дагуу нэгэн амьдралыг цогцлоох шаардлагатай. Учир нь судруудын илгээгдсэн зорилго нь, уншигдах, ойлгогдох ба амьдралд хэрэгжүүлэх явдал юм.

Сүүлчийн ариун судар: Куран Карим



*“Та нарт тийм нэгэн зүйлийг үлдээж байна
түүнийг чанд сахиваас хэзээ ч замаасаа
төөрөлдөхгүй. Тэр бол Аллахын Судар юм.”⁹*
(Гэгээн Мухаммед^(с.а.у))

Куран Карим, Агуу Аллахын Гэгээн элчийн тусламжтайгаар хүн төрөлхтний төлөө дуугарсан сүүлчийн айлдвар, сүүлчийн судар юм. Аллах, тус судрыг илгээсэн ба энэ ертөнцийн төгсгөл хүртэл түүнийг хамгаална гэдгээ тодорхой айлдсан.¹⁰ Кураны бусад судруудаас ялгардаг онцлог нь, ямар нэгэн газар ба аль нэг үндэстэнд биш, бүх хүн төрөлхтөнд илгээгдсэн ба хэзээ ч үл хувьсах явдал юм.

Хэн нэгэн хүн Мусульман болохын тулд Куран Каримд заавал итгэх шаардлагатай. Куран судар, Ислам шашны үндсэн эх сурвалж нь юм. Ислам шашин, Куран судар илгээгдсэн өдрөөс хүмүүст хүрч эхэлсэн. Куран судрын илгээгдэх үйл явц дуусмагц төгс төгөлдөрт хүрсэн.

9 Мүслим, Хаж, 147.

10 Хижр, 15/9.

Куран судар, Рабб (Аллах) эзний нэгэн сургаал, зүрх сэтгэлийн эм нь юм. Үгнүүдийн хамгийн сайхан нь, бидний Гэгээн элчийн хамгийн том гайхамшигт явдал нь юм. Итгэгсэд хамтдаа нягт нямбай атгах ёстой найдвартай нэгэн уяа мэт, шулуун дардан зам руу чиглүүлэгч ба өршөөл нигүүлслийн хэрэгсэл юм.

Хүмүүний хувьд энэ ертөнц болон нөгөө ертөнцийн аз жаргал нь Куран сударт нууцлагдаж байдаг. Мөн хүн төрөлхтний нэгдэж чадаагүй асуудлуудын учрын тайлал, өнгөрсөн ба ирээдүйн талаарх маш олон үйл явдлын мэдээлэл Куран сударт агуулагдсан байдаг. Итгэл сүсэг бишрэл, залбирлууд ба ёс суртахууны үндсэн зарчмууд Куран судраар тодорхойлогддог.

Куран Каримийг унших, уншуулах, сурах ба сургах нь Мусульман хүний хувьд нэгэн үүрэг мөн буян хишгийг авчирдаг. Мэдээжийн хэрэг Куран судар зөвхөн уншигдахын тулд илгээгдээгүй! Үүний зэрэгцээ хүмүүсийг түүний талаар тунгаан бодох, түүнийг ойлгох зам руу тэмүүлэх ба айлдваруудад нь зохистойгоор амьдрахын тулд илгээгдэн ирсэн. Куран судрын айлдваруудыг хамгийн сайн ойлгосон, ойлгуулсан ба амьдралдаа хамгийн сайн хэрэгжүүлсэн хүн Гэгээн элч (с.а.у) юм. Тийм учраас Куран Каримийн гэрэлтүүлсэн дардан замаар явахыг хүссэн хэн нэгэнд хамгийн хялбар сонголт Гэгээн элч Мухаммед (с.а.у)-ын амьдралаас үлгэр жишээ авах явдал юм.

Гэгээн элч нарт иман (итгэн сүсэглэх)



“Аллах болоод гэгээн элчүүдийг эсэргүүцэн,
түүнийг бие биеэсээ холдуулах санаа
өвөртлөгсөд, тэрчлэн гэгээн элчнүүдийн
заримд нь итгэж нөгөөд нь үл итгэж,
завсрын замаар оролдогсод бий. Тэд бол
жинхэнэ буруу номтон мөн.”¹¹

(Куран Карим)

Элч нар, Аллахын зүгээс сонгогдсон ба хүмүүст тэнгэрлэг захиасыг хүргэх үүрэгтэй юм. Элч нарт итгэх нь, тэдний Аллахын ариун гэгээн элч болохыг хүлээн зөвшөөрөх нь Аллахын зүгээс бидэнд хүргэсэн бүх зүйлд нь итгэл хүлээлгэсэн гэсэн үг юм.

Элч нарт итгэх нь, Исламын үндсэн зарчмуудын нэг юм. Тэдний дунд өөр өөрийн гэсэн онцлогтой ба давуу талуудтай болохын хамтаар, Исламын үүднээс, итгэл сүсэг бишрэлийн хувьд авч үзвэл элч нар ба тэдэнд

¹¹ Ниса, 4/150-151.

илгээгдсэн айлдваруудын дунд огтхон ч ялгаагүй билээ. Тиймээс Мусульман хүн, ямар ч ялгаа гаргахгүйгээр бүх элч нарыг хүлээн зөвшөөрч, хайр ба хүндэтгэлтэйгээр тэднийг дурсан санаж, тэднээс үлгэр жишээ авах ба Сүүлчийн элчийг дагадаг.

Хамгийн анхны хүн гэгээн Адам, түүний хажуугаар хамгийн анхны гэгээн элч юм. Хамгийн сүүлчийн элч бол гэгээн Мухаммед Мустафа (с.а.у) юм. Агуу Аллах эзэн хүн төрөлхтнийг хэзээ ч чиглүүлэгчгүй, үлгэр жишээ харуулах нэгэнгүй, удирдагчгүй, элчгүйгээр үлдээгээгүй. Энэ хоёр элчийн хооронд нэрс нь мэдэгдэх ба үл мэдэгдэх, өөрсдөд нь ном судар илгээгдсэн ба илгээгдээгүй маш олон элч нар ирж буцсан. Тэд бүгдийн урин дуудсан зүйл нь бол адилхан: Аллахын албат болох буюу мөргөн залбирцгаа!

Элч нар Аллах буюу Бурхан тэнгэрийн захидлыг илүү дутуугүйгээр хүргэх үүрэгтэй. Гэхдээ тэр үүрэг нь мэдээллийг зөвхөн хүргэх явдал биш юм. Түүний хажуугаар илахи буюу бурханлаг мэдээг тайлбарлах, түүнд зохимжтойгоор амьдрах ба хүмүүст үлгэр жишээ болох ч гэсэн элч нарын үүрэг хариуцлага юм. Энэхүү замд маш олон асуудлууд ба зовлон бэрхшээлийг тэсвэрлэн, зарим үед Аллахын зөвшөөрлөөр гайхамшгуудыг харуулсан элч нарын түүхийг Куран сударт сургамж болгох үүднээс өгүүлсэн байдаг.

Хүний оюун ухаан, Агуу нэгэн Бүтээгч Бурхан тэнгэр бий гэдгийг ухамсарлах чадвартай ч

гэсэн, түүний айлдвар болон зарлигуудыг нь элч нарын тусламжтайгаар мэдэж авдаг. Тийм учраас Аллахын зарлигуудад захирагдах ба хоригуудаас нь зайлсхийхийг хүссэн хүний, элч нарын үлгэр жишээнд тулгуурлах шаардлагатай. Ариун судруудад итгэхийн тулд эхлээд өөрт нь судар илгээгдсэн элчид итгэх хэрэгтэй.

Элч нар нь, хэлсэн ярьсан нь нэг, зөв, үнэнч шударга, ухаалаг, хүлээцтэй, нүглээс хамгаалагдсан нэгэн юм. Хүмүүст Аллахын айлдваруудыг уншин танилцуулж, судар болон мэргэн ухааныг сургадаг, тэднийг цор ганц Бурхан тэнгэр ба сайн сайханд урин дуудаж Бурхан тэнгэрийг үгүйсгэхээс болон муу муухайгаас хол байлгадаг хүмүүс юм. Эргэлзээ үгүй билээ, элч нарын гинжин хэлхээний хамгийн сүүлийн бөгөөд хамгийн төгс хэлхээ нь бол гэгээн Мухаммед (с.а.у) болсон юм.

Сүүлчийн Элч Гэгээн Мухаммед (с.а.у)



*"Аяа, Гэгээн элч ээ! Бид чамайг чин үнэнийг
гэрчлэгч, баярт мэдээг дуулгагч, сэрэмжлүүлэгч
болгон илгээсэн юм шүү. Тэрчлэн, Алладын
болгоосноор Түүний цорын ганц гэдэгт,
ивээл энэрэлд уриалан дуудах гэрэлт
дэнлүү болгон чамайг илгээсэн билээ.¹²
(Куран Карим)*

Исламын элч гэгээн Мухаммед Мустафа (с.а.у), Алладын албат элч, элч нарын хамгийн сүүлчийнх юм. Исламыг хүлээн зөвшөөрсөн хүн бүр, келиме шахадат хэлснээр «Аллахаас өөр бурхан үгүй ба гэгээн элч Мухаммед (с.а.у) Түүний албат элч болохыг нь» гэрчлэн хэлэх үүрэгтэй.

Ертөнц дэлхийд энэрэл нигүүлслээр илгээгдсэн Гэгээн элч (с.а.у), хүчирхийлэл ба харанхуй нөмөрсөн нийгэмд амьдарсан бөгөөд хайр энэрэл ба шударга үнэн рүү хөтөлсөн. 23

12 Ахзаб, 33/45-46.

жил үргэлжилсэн элчийн үүргийн хүрээнд тэвчээртэйгээр, хүлээцтэйгээр, итгэлтэйгээр болон энэрлээр үлгэр жишээ нэгэн Исламын нийгмийг бий болгосон.

Бидний гэгээн элч Куран Каримийг хамгийн сайн ойлгосон ба амьдралынхаа хором бүрт амилуулсан үлгэр жишээ хүн юм. Түүний эргэн тойрон дахь болон эрин зуун ба тив дэлхийг алгасан бүх Мусульманчуудын хувьд хамгийн том жишээ юм. Элчийн үүрэг оноогдохоос өмнө ч гэсэн “Мухаммед’ул-Амийн” (Итгэлт Мухаммед) хэмээн танигдсан, төлөвшил ёс суртахууны оргил нь байсан юм. Тэр, шударга үнэн ба үнэн зөвөөс хэзээ ч бууж өгөөгүй, шударга үнэнийг, хүний эрх ба халдашгүй байдлыг хүндлэхийг, эрдэм мэдлэгийн үнэ цэнийг ба олноороо хуралдаж гаргасан шийдвэр чухал болохыг хүмүүст сургасан.

Асхаб буюу түүнтэй хамт амьдарч байсан мүминчүүдийн хэлснээр бид мэдэж авсан, Алладын элч (с.а.у) өгөөмөр сэтгэл ба тусламж үзүүлэхдээ гар татдаггүй байсан. Амьдралынхаа турш өөрт нь тусалж байсан нэгнийг аль эсвэл эхнэрээ гомдоох үйлдэл хийж байгаагүй. Энгийн бөгөөд даруухан амьдарсан, Алладын айлдваруудыг зөрчсөн тохиолдолд уурладаг, түүнээс гадна хэн бүхэнтэй эв найрамдалтай, уучлагч, сайхан сэтгэлээр зөөлөн ханддаг байсан. Зөөлөн зүрх сэтгэл нь, инээмсэглэлтэй харц нь, итгэл өгөх хоолойн өнгө нь, язгуурт байдлаараа хосгүй нэгэн хүн байсан.

Аллах руу хүрэх зам, Гэгээн элчид холбогдон түүнд итгэн дагахаас эхэлдэг. Мусульман хүн бүр энэ ертөнцөд аз жаргал нь нөгөө ертөнцөд авралын гарц нь, Гэгээн элчийг дагаж түүний замналд зохистой амьдралаар амьдрах нэгэн байх хэрэгтэй юм.

Ахирет буюу нөгөө ертөнцөд иман итгэн (сүсэглэх)



*‘Тэд, уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлдэж,
ариуслын өглөг өгдөг нэгэн. Тэд хойд
ертөнцөд баттай сүсэглэн итгэцгээдэг.’¹³
(Куран Карим)*

Ахирет буюу нөгөө ертөнц нь, энэ ертөнц дэлхийн амьдралын дараа эхлэн эцэс төгсгөлгүй үргэлжлэх амьдралын нэр нь юм. Ахиретед итгэх нь, Мусульман болохын үндсэн зарчмуудын нэг нь юм. Ахиретед итгэх Аллаhad итгэх хоёрын хооронд шууд болон салшгүй нэгэн холбоо байдаг. Учир нь хүний ахиретийг үгүйсгэх нь, шалгуурын ертөнцийг бүтээсэн ба энэ хорвоо ертөнц түр зуурынх гэдгийг нь дуулган ахиретийн тухай хүн төрөлхтнийг мэдээлэлтэй болгосон Аллахыг үгүйсгэсэнтэй адил юм.

Дэлхий сөнөх ба энэ ертөнцийн төгсгөл ирснээр, ирсэн буцсан бүх хүмүүс Аллахын бурхан тэнгэрийн өмнө хариуцлагаа хүлээх

болно. Ариун шударга ёс илэрч, сайн муу, дарангуйлагч ба дарлуулсан, буруугүй ба буруутан нэг нэгнээсээ ялгарах ба хэн бүхэн хийсэн зүйлийнхээ шан харамжийг бүрэн гүйцэт хүртэх болно.

Ахиретед итгэх нь, хүний ухамсар хариуцлагыг хөгжүүлдэг. Тэнгэр газрын эзэн болсон Аллах нэгэн өдөр хүмүүнд өгсөн буян хишгүүд ба түүнд даатгаж өгсөн зүйлүүдийн талаар хариуцлага хүлээн гэдгээ мэдэх нь, хүнийг хариуцлагатай болгоомжтой хандахад хүргэдэг. Энэхүү хариуцлага нь, нийгмийн харилцаанаас байгаль ертөнцтэй хандах хандлага ба үйл ажиллагааг хүртэлх Мусульман хүний бүхий л харилцааг хамардаг.

Түүнээс гадна ахиретед итгэх нь, хүний амьдралыг тодорхой нэг зорилго руу чиглүүлэн, зөв зүг рүү тэмүүлэн сайн сайханд зориулагдахыг хангадаг. Өс хонзон, атаархал, дайсагнал, үзэн ядалт гэх мэт мэдрэмжүүдийг хазаарлан, уучлах, өршөөх, горьдлого найдвар ба тэвчээртэй болох гэх мэт эерэг хандлагуудыг хөгжүүлдэг. Амьдрал дахь бэрхшээлүүдийн эсрэг тэмцэх хүч өгдөг ба хүлээцтэй хандсан зарим үед олж авч чадаагүй шударга ёсны эрлийн хариултыг олж авдаг.

Ахиретед итгэх нь, үхлийг үргэлж санадаг ба үхлийн дараах амьдралын төлөө хамгийн сайнаар бэлтгэлээ хангасан хүн, мүминчүүдийн хамгийн ухамсартай нь юм. Учир нь хамгийн сайн хөрөнгө оруулалт, диваажинг хамруулсан мөнхийн орон зайд хийсэн хөрөнгө оруулалт юм.

Хувь Тавиланд Иман (Итгэн сүсэглэх)



*«Бид аливаа юмсыг тодорхой
хэмжүүрээр бүтээсэн.»¹⁴
(Куран Карим)*

Бүх зүйлийг оргүйгээс бүтээсэн Аллах, ертөнцөд болсон ба юу болох бүгдийг нь шалтгаан-үр дүнгийн харилцаанд тулгуурлан бүтээхийг хүссэн. Ийнхүү оюун ухаан гэх мэт дээд зэргийн авьяас чадвараар хангагдсан хүн, оршихуй дахь мэргэн ухаан ба үнэний мөн чанарыг илүү ухаарах болно. Чухамдаа орчлон ертөнцийг нухацтайгаар шинжсэн нэг хүн, ертөнцөд эмх замбараагүй байдал бус, хувь тавилангийн хэмжээ, тэнцвэр ба эмх цэгцтэй зохицсон болохыг олж харна. Энэхүү байдал нь Агуу нэгэн Бүтээгч байгаа гэдэгт чиглүүлдэг.

Хувь тавиланд итгэх нь, Исламын зургаан үндсэн иман буюу итгэлийн зарчмын нэг нь юм. Орчлон ертөнцөд сайн-муу, зөв- буруу,

14 Камер, 54/49.

амьд-амьгүй, ашигтай-ашиггүй юу тохиолдсон ч гэсэн бүгдийг нь Аллах мэднэ, мөн түүний хүссэнээр, хүч, таалал ба бүтээснээр биелдэгт нь чин сэтгэлээсээ итгэхийг хэлнэ.

Амьдралд хүний хүчийг давсан ба оролцоо нь боломжгүй тохиолдлууд байдаг. Жишээлбэл ертөнцийн үйл ажиллагааг нь, амьтдын олшрох системийг, байгалийн үзэгдлүүдийг, аянга цахилгаан цахих ба газар хөдлөлтийг хэн ч зогсоож үл чадна. Үүний адилаар хүн хорвоо ертөнцөд мэндлэхдээ гэр бүлээ, үндэс угсаагаа, өнгө зүсээ, хүйсээ сонгон төрөх боломжгүй. Энэхүү илахи (бурханлаг) нэгэн тодорхойлолтын үр дүнд бий болж үүсдэг ба үүнийг кадер буюу хувь тавилан гэдэг.

Нөгөөтээгүүр, сайн эсвэл муу зүйлүүд үйлдэгдэхэд хүний оролцоо ч гэсэн байдаг. Аллах, өөрт нь буй хязгааргүй эд хөрөнгөд хүмүүсийн эргэлдэх орон зайг олгож, тодорхой нэгэн орон зайд сонголт хийх эрхийг олгосон. Мөн үүний хажуугаар нэгэн сайн үйлийг үйлдэх эсвэл нэгэн муу муухайг үйлдэх нь тухайн хүний сонголтод үлдээсэн. Ийм тохиолдлуудад Аллахын бий болгож бүтээх нь, хүний хичээл зүтгэл ба шийдвэртэй уялдаа холбоотойгоор бий болдог. Тиймээс хүний авсан арга хэмжээ ба хийсэн сонголтууд ч гэсэн хувь тавилангийн нэг хэсэг юм.

Орчлон ертөнцөд юу ч тохиолдсон ч, Аллах хэзээнээс мэддэг ба бүртгэгдсэн байдаг. Бид бүтээгдэхээсээ өмнө юутай нүүр тулахыг хамгийн жижиг нарийн зүйлийг хүртэл мэдэх

Аллах, бидний сонголтоо яаж ашиглахыг өмнөх ба мөнхийн мэдлэгээрээ мэддэг. Гэвч энэхүү байдал нь, Аллах эзэн биднийг шахан, салхинд хийсэх хуурай навчсын адил хуйлран гэсэн үг биш юм. Аллахын болох үйл явдлыг урьдчилан мэдэх нь, хүний үүрэг хариуцлагаас мултрах боломжгүй. Жишээлбэл хулгай хийсэн нэг хүн, Аллах түүнийг үйлдэхийг нь мэдсэнийх нь тулд биш, өмнөө байгаа хоёр сонголтоос муухайг нь сонгож хулгайг мэдсээр байж үйлдэж сонгосон тул түүнийг үйлддэг. Тиймээс сонголтынхоо болон үйлдсэн хэргийнхээ хариуцлагыг үүрдэг.

Хүнийг энэ ертөнцөд нөгөө ертөнцөд аз жаргал болон азгүйдэлд түлхдэг зүйл нь, үнэндээ өөрийнх нь үйлдсэн зүйлүүд нь юм. Хамгийн гол нь хүн, хүсэл зорилгоо сайн сайхан руу чиглүүлэн, муу муухайг сонгохгүй байх нь чухал юм. Учир нь хүн бүр сонголтынхоо үр дүнг үүрэх ба үйлдэгдсэн үйлийг хувь тавилантай холбон хариуцлагаас хэн ч зугтааж чадахгүй.

Хувь тавиланд итгэдэг хүн, эцсийн мөчид жинхэнэ үйлийн эзэн Аллах болохыг хүлээн зөвшөөрдөг. Гэгээн элч Мухаммед (с.а.у) үүнийг ийн хураангуйлан хэлсэн: *«Үүнийг мэдэж авагтун бүх хүмүүс чамд туслахаар цугласан ч, Аллахын хүслээс гадна чамд тусалж үл чадна. Дахиад бүх хүмүүс чамайг хохироохоор цугласан ч, Аллах хүссэнээс гадна чамайг хохироож үл чадна. Энэ сэдвийн талаар үзгүүд хураагдсан (шинээр нэг зүйл бичигдэхгүй), хуудаснууд хуучирсан (өөрчлөгдөхгүй).»¹⁵*

15 Тирмизи, Сифатул-Кияме, 59.

Жишээлбэл хувь тавиланд итгэсэн хүн, бороо тодорхой физикийн шалтгаануудын улмаас бороо орохыг нь мэднэ. Гэвч түүний хувьд бороо орох нь, байгалийн үзэгдлүүдийн үр дүнгээр хязгаарлагдмал биш юм. Мусульман хүн, харагдаж байгаа өнцгөөс илүүтэйгээр, бороог Аллах оруулдагт нь итгэдэг. Сүүлийн шийдвэр, тушаал, хүсэл ба бүтээх нь эргэлзээгүй Аллахын юм.

Исламын шашинд, хүчин чармайлтгүйгээр амжилтад хүрэх, сууж байгаа газраасаа Аллахаас ямар нэг зүйлийг хүлээх, ингэснээрээ Аллахыг (бурхан) өөрийн үйл хэрэгт төлөөлөгчөөр томилох гэх мэт хувь тавилангийн тухай ойлголт байхгүй. Хувь тавиланд итгэсэн Мусульман хүн, үүргээ хариуцлагатайгаар биелүүлдэг. Шийдэмгий, өөртөө итгэлтэй ба тэвчээртэй ханддаг. Материаллаг болон оюун санааны шалтгаануудын бүгдийг нь болон хийх ёстой бүх боломжуудыг хангасны дараа, Аллахад итгэх ба үр дүнг түүнд даатгадаг.

——
ХОЁРДУГААР БҮЛЭГ
ИБАДЕТ БУЮУ
МӨРГӨЛ
ЗАЛБИРЛЫН
ҮНДСЭН
ЗАРЧМУУД
——

Мөргөл Залбирлын Үндсэн Ойлголтууд



*«Ихсан, Түүнийг харж байгаа мэт Аллахад
мөргөл залбирал үйлдэх юм. Чи Түүнийг
харахгүй ч гэсэн, Тэр чамайг харж байгаа.»¹*
(Тэгээн Мухаммед^(с.а.у))

Аллах эзэн, хүн төрөлхтнийг хамгийн төгс хэлбэрээр бүтээн, энэ ертөнцөд байгаа бүх зүйлийг түүний эрх ямбанд өргөн барьсан. Оюун ухаанаа хэрхэн ашиглах, шийдэл гаргах, сэтгэн бодох, ярих, бичих, сонголт хийх гэх мэт онцлог шинж чанаруудаар түүнийг хангаж өгсөн. Хүн төрөлхтнөөс түүний хүлээлт нь, зөвхөн өөрт нь албат болж сүсэглэх явдал юм.

Албат болох гэдэг нь, Агуу Аллахын өмнө эргэлзээгүй дуулгавартайгаар захирагдан, Түүнд гүн гүнзгий холбогдох ба хүн байхын хариуцлагаа үүрэхийг хэлнэ. Албат байх нь, сайн үйл ба муу муухай үйлдсэн бүх зүйл нь Аллахын зүгээс тодорхой байдаг ба хэзээ нэг

1 Бухари, Тафсир Локман, 31.

өдөр хариуцлага хүлээн гэдгээ мэддэг. Албат болох нь, нэг талаас иман (итгэл) ба хүмүүжил төлөвшлийг шаарддаг ч, нөгөө талаас ибадет буюу мөргөл залбирал үйлдэхийг зайлшгүй шаарддаг. Ер нь ибадет буюу мөргөл залбирал; албатын мөн чанар, хүн төрөлхтний оршихуйн зорилго нь юм. Тийм учраас хүн, өөрт нь тоолж дуусашгүй буян хишгийг хайрласан Рабб эзнээ умарталгүйгээр, мөргөл залбирлаа үйлдэн албатын ухамсраа санаж явах хэрэгтэй.

Мөргөл залбирал нь, хором мөч ба бүх талаараа Агуу Аллахын ивээлээр дутагдаж гачигддаг хүн нь, ямар нэгэн зуучлагчгүй ба шууд хэлбэрээр өөрийнхөө байдлыг Түүнд илэрхийлэхийг хэлнэ. Иман буюу итгэлийн зарчмуудыг хүлээн зөвшөөрсөн нэгэн хүн, энэхүү итгэл сүсэг бишрэлээ хамгаалан хадгалах ба хүчирхэгжүүлэхийн тулд мөргөл залбираалаа тууштайгаар үргэлжлүүлэх хэрэгтэй.

Ислам шашны айлдсан болон боломжтой Мусульман хүн бүрийн үйлдэх үүрэгтэй үндсэн мөргөл залбирлууд байдаг. Тэдгээр нь, келиме-и шахадат гэрчлэх үгийг хэлэх буюу Аллахаас өөр бурхан тэнгэр үгүй болохыг мөн гэгээн Мухаммед Түүний албат ба элч гэдгийг нь гэрчлэх, намаз мөргөл үйлдэх, зекат буюу өглөг өгөх, хаж мөргөлийг гүйцэлдүүлэх ба Рамазан буюу мацгийн сард мацаг барих багтдаг.

Фарз буюу заавал биелүүлэх үүрэгтэй мөргөл залбирлаас гадна, сайн санаагаар ба чин сэтгэлээсээ үйлдсэн бүхий л ажил мөргөл залбирал мэт буян хишгийг хураадаг. Энэ

хүрээнд, сайн сайхныг зөвлөж, муу муухайг хориглон, хүмүүсийн дунд шударга үнэнийг тогтоох, гэр бүлээ тэжээх хэрэгцээг нь хангах, мэндлэх, хүмүүсийг инээмсэглэлээр угтах, садака буюу өглөг өгч буян үйлдэх гэх мэт үйлдлүүд ч гэсэн нэгэн мөргөл залбирал юм.

Тухайн хүн эхнэр, ээж-аав болон хүүхдийнхээ төлөө сайн үйл үйлдэх нь, төрөл садан ба хөрштэйгөө сайн сайхнаар харилцан, гунигтай байгаа нэгнийхээ нулимсыг нь арчих, өнчин нэгний толгойг илэх, амьдралын боломжгүй нэгэн оюутанд туслах, настай нэгэнд хүндэтгэлтэй хандах, хөгжлийн бэрхшээлтэй нэгэнд туслах гэх мэт сайныг зорьсон үйлдэл бүхэн нэгэн мөргөл залбирал юм.

Хэн нэгэн хүн мэдлэг ба туршлагаасаа хуваалцах нь, шударга үнэн ба итгэж болох хэлбэрээр худалдаа наймаа хийх, хорт муу зуршлуудаас залуу үеэ хамгаалахын төлөө чармайлт гаргах нь, байгаль орчноо хамгаалах ба амьтдын эрхийг ч гэсэн хамгаалах мөргөл залбирлын нэгэн хэлбэр юм.

Муу муухай ёс суртахуунаас хол байхыг хичээж, сайн сайхан дадал зуршил олж авах ба өөрийгөө сахилгажуулахыг эрмэлзэх, хүрээлэн буй орчныхоо хүмүүст хүндрэл учруулах бус хөнгөвчлөхийг чухалчилдаг хүн, мөргөл залбирлын ухамсарт эзэн болохыг харуулдаг.

Мөргөл залбирал, хүнийг сул дорой байдлаас ангижруулан, сахилга бат, түүнд талархал, сонголт ба тэсвэр тэвчээрийг сургадгаараа онцлогтой юм. Хүмүүс заримдаа намаз

мөргөлөөр цаг хугацааны сахилга батыг, мацаг барьснаар буян хишгийн ач тусыг, хаж мөргөлөөр эрх тэгш болон ах дүүгийн харилцааг, зекат өглөгийг өгснөөр хуваалцахыг суралцдаг. Мөргөл залбирал эхлээд харахад тодорхой дүрмүүд, хэлбэр ба дүрстэй харагдах боловч үнэндээ энэ хэлбэрүүд дотор Аллахад чиглэсэн хайр, хүндлэл ба захирагдахын язгуур нь нууцлагдаж байдаг.

Мөргөл залбирал үйлдэх нь түүний хажуугаар хүнийг амиа хичээхээс, их зан, хардлага, атаархал, үрэлгэн байдал, шунал, харамлах ба түүнтэй төстэй муу муухай мэдрэмж ба бодлоос ариусгадаг. Мөргөл залбирал хүнийг, сурган хүмүүжүүлж, тэлж, өргөжүүлэн, өөрт нь болон нийгэмд ашиг тустай мумин болоход нь тусалдаг.

Келиме-й шахадат



*«Ислам таван үндсэн зарчим дээр суурилдаг:
Аллахаас өөр бурхан тэнгэр үгүй болохыг
Мухаммедийг Алладын элч болохыг нь
гэрчлэх, намаз мөргөл үйлдэх, зекат буюу
өглөг өгөх, хаж мөргөлийг гүйцэлдүүлэх
ба Рамазан буюу мацгийн сард мацаг
барих.» (Гэгээн элч Мухаммед с.а.у)²
(Гэгээн Мухаммед^(с.а.у))*

Ислам шашны гол төвд нь «таухид» буюу цор ганц Аллахад иман (итгэх) зарчим байдаг. Энэхүү зарчмын хэллэг нь буюу Мусульман болохын хамгийн эхний болзол нь бол «Келиме-й шахадат» буюу «Ашхаду аль ла илаха иллаллах уа ашхадү анна мухаммедан абдухү уа расулух» өгүүлбэр нь юм. Келиме-й шахадат, «Аллахаас өөр бурхан тэнгэр үгүй болохыг Мухаммедийг Алладын албат ба элч болохыг нь гэрчлэх болно», гэсэн утгатай.

Энэ өгүүлбэрээрээ хүний гэрчилж буй хамгийн анхны зүйл нь, Аллахаас өөр бурхан

2 Бухари, Иман, 2.

тэнгэр үгүй болохыг хэлдэг. Келиме-й шахадат хэлсэн хэн нэгэн, Аллахаас өөр залбиран тусламж хүсэх ямар нэгэн хүч чадлын эзэн үгүй болохыг, буян хишгийг зөвхөн Аллахаас ирдэг ба зөвхөн Түүнээс хүсэх, зөвхөн Аллахад итгэн, бусад ямар ч оршихуй руу зүглэхгүйгээр, зөвхөн Аллахад мөргөн залбирах ба Түүнээс тусламж аврал эрэхийг хүлээн зөвшөөрсөнд тооцогддог.

Келиме-й шахадатын хоёр дахь бидний гэрчилсэн зүйлийн нэг нь бол «Гэгээн Мухаммедийн, Алладын албат ба элч болохыг нь» гэрчилдэг. Юуны өмнө Сүүлчийн элч гэгээн Мухаммед (с.а.у) Алладын албат, үүний зэрэгцээ бидэнтэй адил хүн юм. Гэгээн Исаг (Есүс) тахин шүтэх гэх мэт байдал Гэгээн элчийн хувьд огтхон хүлээн зөвшөөрөгдөхгүй юм. Түүний хажуугаар Гэгээн Мухаммед (с.а.у) эгэл жирийн нэг албат биш, чухамдаа Алладын элч нь юм. Түүнд айлдвар илгээгдсэн ба түүнийг илгээгдсэн байдлаар нь хүмүүст хүргэн, ойлгуулах ба амьдрах үүрэгтэй байсан. Тэр, үргэлж Алладын хяналт ба хамгаалалтан дор байсан.

Ариун Цэвэр



“Ариун цэвэр нь итгэл сүсэг
бишрэлийн тал нь юм.”³
(Гэгээн Мухаммед^(с.а.у))

Ислам шашны хамгийн онцлог шинж чанаруудын нэг нь, материаллаг болон оюун санааны цэвэр ариун байдлыг чухалд тооцдог. Материаллаг зүйлсийн ариун цэвэр нь, тухайн хүний өөрийн бие, хувцас, эд зүйл, амьдарч байгаа орчин, эргэн тойрон ба бүхлээр нь энэ ертөнцийг цэвэр байлгах юм. Оюун санааны ариун цэвэр нь, бие сэтгэлээ ариусгах, сэтгэл зүрх болон тархиа цэвэр байлгах, муу муухайгүйн хар мөр ба нүглийн хирээс хол байхыг хэлнэ.

Ислам шашин нь, хүний бие махбодтой холбогдолтой хаягдлуудыг хүрээлэн буй орчинтойгоо холихгүй байхыг тушаадаг. Тийм учраас ариун цэврийн өрөөнд орох ёс зүйн болон ариун цэврийн талаар Гэгээн элчийн сургаалд онцгой нэгэн орон зайг эзэлдэг. Бие засч буй хүн

3 Тирмизи, Дагауат, 86

заавал усаар цэвэрлэн, бусдын нууцад анхааран, кибле руу чиглэхгүй, баруун гараа ашиглахгүй ба ариун цэврийн өрөөнөөс гарахдаа гараа угаах нь сүннет буюу буян хишигтэй үйлдэл юм. Түүнээс гадна хүмүүсийн явах замд, модны доор, сүүдэр газарт, парк хүрээлэнгийн газарт, ус мөрөн голын эрэгт бие засах нь хориотой юм.

Исламын шашинд биеийн ариун цэвэрт онцгой анхаардаг. Аллахын элч (с.а.у), долоо хоногт хамгийн багадаа нэг удаа Баасан гаригт тохируулан усанд орох буюу дууш авах, цэвэрхэн хувцаслах, үс ба сахалдаа анхаарах, хумсаа авах цэвэрхэн байлгахыг шаарддаг. Мусульман хүн хэзээ ч хүрээлэн буй орчиндоо муухай үнэр тараан төвөг учруулан, бохир байдалтайгаар явдаггүй, өөртөө анхаарал хандуулдаггүй байж таарахгүй.

Исламын шашинд зарим мөргөл залбирлыг үйлдэхийн тулд ариун цэврийг эхний шаардлага болгон тавьсан нь анхаарал татууштай. Намаз мөргөл үйлдэхийг хүссэн нэгэн Мусульман «уду» биеийн тодорхой хэсэгтээ угаалга цэвэрлэгээ хийдэг. Шаардлагатай тохиолдолд, бүх биеийг угаах гэсэн утгатай «гусул» угаалгыг үйлддэг. Ус олдохгүй тохиолдолд цэвэр шороогоор «тайаммум» авах нь ч гэсэн энэхүү ариун цэврийн нэгээхэн хэсэг юм.

Мусульман, материаллаг цэвэрлэгээ адил, оюун санааны ариун цэврийг ч гэсэн чухалчилдаг. Нүглүүддээ гэмших ба таубе буюу харамсах уучлал өршөөл эрж нүглээсээ ариусдаг. Буруутай үйлдэлдээ харамсан Аллахаас өршөөл

эрэх ба дахин үйлдээгүй Мусульман, цаашид тэр нүглээсээ ангижран ариусдаг.

Оюун санааны ариуслын хөрөнгө нь ёс зүй хүмүүжилд нууцлагдаж байдаг. Гар, хэл, нүд, бүхий л биеийг сайн сайхны төлөө зориулах ба муу зуршлуудаас хол байлгах, оюун санааны ариун цэвэрт хүрэх замыг нь Ислам шашнаас олж харж болно.

Угаалга ба бүтэн биеийн угаалга



*“Диваажингийн түлхүүр нь намаз мөргөл,
намаз мөргөлийн түлхүүр нь угаалга юм.”⁴*

(Гэгээн Мухаммед^(с.а.у))

Ислам шашны хувьд, мөргөл залбирал үйлдэх зорилгоор Аллахын өмнө зогсох нэгэн хүн эхлээд материаллаг болон оюун санааны хувьд ариун цэврээ сахин, өөрийгөө ариусгах хэрэгтэй. Энэхүү ариун цэврийн төвд нь биеийн тодорхой хэсгүүдийн угаалга ба бүтэн биеийн угаалга оршдог.

Мөргөл залбиралд бэлдэж буй хүн, угаалга үгүй үед угаалга, бүтэн биеийг хамарсан угаалга байхгүй үед бүтэн биеэ угааснаар материаллаг болон оюун санааны үүднээс ариун цэврээ сахидаг. Учир нь угаалга нь үгүй нэг хүн, намаз мөргөл үйлдэж болохгүй.

Угаалгын фарз буюу заавал үйлдэх ёстой зарчмууд нь: Нүүрээ, гараа тохойн хамтаар

4 Тирмизи, Тахарет, 1.

ба хөлөө шагайн хамтаар угаах, толгойдоо чийгтэй гараараа хүрэх юм. Гэгээн элч (с.а.у)-ын дагагсдадаа сургасан хэлбэрээр нь угаалгын сүннет буюу үйлдэх аваас буян, угаалгыг чимж өгдөг Гэгээн элчийн үйлдлийн хэлбэрүүд нь: Угаалга эхлэхдээ Аллахын алдраар эхлэх, угаалга хийхдээ амаа усаар зайлах, хамрынхаа хөндийг хоёулынх нь усаар зайлж цэвэрлэх, толгойн урд болон хойд хэсэг буюу толгойныхоо бүх хэсэгт гарын алгаараа хүрэх, чихээ цэвэрлэх, угаалгын биеийн хэсгийг гурван удаа угаах ба шувтрах, хурууныхаа хоорондох завсрыг хуурай үлдээхгүй байх.

Хүн төрөлхтөнд, цэвэр ариун бие сэтгэлээр үргэлж Рабб эзэн рүүгээ чиглэх боломжийг олгосон ариун цэврийн зарчмуудын нэг нь бүтэн биеийн угаалга юм. Гусул буюу бүтэн биеийн угаалга нь, бүтэн биеэ угааснаар хүний бие организмын хирийг мөн нүглийн хирийг цэвэрлэдэг.

Бэлэг эрхтнээс үрийн шингэний дусал гарах, үрийн шингэн гарсан гараагүй бэлгийн харьцаанд орох, эмэгтэй ба эрэгтэй нойтон зүүд зүүдлэх, эмэгтэйчүүдийн сарын тэмдэг төрсний дараа гарч буй цус тогтсон үед заавал гусул буюу бүтэн биеийн угаалга үйлдэх хэрэгтэй.

Бүтэн биеийн угаалга үйлдэх үедээ эхлээд бисмилла хэлэх ба гусул буюу бүтэн биеийн угаалгыг төлөвлөнө. Дараа нь амандаа ба хамартаа ус аван цэвэрлэх ба намаз мөргөлийн төлөө үйлдэгдэх угаалгын адил үйлдэнэ. Хамгийн сүүлд нь толгойноосоо хумсандаа

хүртэлх бүх биеэ, огтхон ч хуурай газар үлдээхгүйгээр угаана.

Угаалга ба гусул бүтэн биеийн угаалга үйлдэхдээ усаа их хэмжээгээр үрэлгүйгээр, яаран ба хайхрамжгүй хандахыг хориглодог. Гэгээн элчийн ихэнх хадис буюу үгнүүдэд, сайнаар угаалга үйлдсэн хүний нүглээсээ ариусах талаар баяртай мэдээнүүд байдаг. Тиймээс Мусульманы цэвэр ба ариун байх нь, тайвшран амар амгаланд хүрэх нь, түгшүүр ба стрессээ тайлах, мөн буян хишигт хүрэх замыг нь хангасан угаалга нь, томоохон нэг буян хишиг юм. Шаардлагатай тохиолдолд бүтэн биеийн угаалга үйлдсэн Мусульман, намаз мөргөл үйлдэхэд бэлэн болсон гэсэн үг.

Намаз мөргөл



*“Намаз мөргөл үйлдэгтүн, зекат өглөг
өгөгтүн. Рукуг үйлдэгсэдтэй хамт
та нар ч гэсэн рукуг үйлдэгтүн.”⁵
(Куран Карим)*

Ислам нь келиме-й шахадатын дараа үүрэг болгосон мөргөл залбирлын эхэнд намаз мөргөл байдаг. Намаз мөргөл нь, такбираар эхлэн салем буюу мэндлэхээр төгсдөг, тодорхой үйл хөдлөлөөр ба уншлагаас бүрдсэн онцгой нэгэн мөргөл залбирал юм. Намаз мөргөл нь, албатын гүн хүндэтгэл, хайр болон болгоомжтойгоор Аллахын өмнө зогсох нь, чин сэтгэлээсээ Түүнд залбирах ба талархахыг хэлнэ.

Рабб эзний бидэнд өгсөн буян хишигт талархах нь, Исламын ба хүн чанарын үүрэг юм. Буян хишгийн талархал нь өөрийнх төрлөөс байх хэрэгтэй. Нэг үгээр хэлбэл, материаллаг болон оюун санааны үүднээс авч үзвэл бидний эзэн сууж буй төрөл бүрийн боломж ба буян хишгийн талархал нь, түүнийг Аллах

5 Бакара, 2/43.

руу чиглүүлснээр талархал болдог. Бидний биемахбодь, ухаан санаа, ярих чадвар, эрүүл мэнд зэрэг нь бидэнд хайрласан хамгийн үнэ цэнэтэй буян хишгүүд юм. Тиймээс намаз мөргөл нь бие организмаар үйлдэгддэг нэгэн мөргөл залбиралын хувьд тэдгээр буян хишгийн төлөө Аллахад талархалаа илэрхийлж буй хэлбэр юм.

Куран-Карим, түүхэн он жилүүдийн турш бүх элч нар өөрсдийн дагаж буй хүмүүстээ намаз мөргөлийг зарлигдсан талаар өгүүлдэг. Мэдээжийн хэрэг тус бүрийн элч нарыг дагасан хүмүүсийн намаз мөргөл өөр өөр онцлог шинж чанарыг агуулж байсан. Мусульман хүний намаз мөргөл нь, Гэгээн Элчийн зааж сургасан ба харуулсан хэлбэрээр өдөрт таван удаа кибле (меккегийн зүг харах) руу чиглэн үйлддэг. Бие, тархи ба оюун санаа болон зүрх сэтгэлийн нэгдлээр мөргөл залбиралд анхаарсан хүн, намаз мөргөл өөрийг нь бүх талаар нь хүрээлснийг мэдэрдэг. Киямд зогсохдоо Аллахын өмнө зогсдог, рукугд байхдаа зөвхөн түүний өмнө бөхийж, саждед бол Аллахад хамгийн ойрхон цэгт Түүнийг хэрхэн сүсэглэн дагаж буйгаа илэрхийлдэг.

Ислам шашны багана нь, муу муухайгын эсрэг хамгаалах систем нь, нүглүүдийг наминчлахад гол үүрэг гүйцэтгэгч, хүний ахирет буюу нөгөө ертөцөд нэн түрүүнд тооцоог нь тушаадаг хамгийн чухал мөргөл залбирал намаз мөргөл юм. Намаз мөргөлөө тасалдуулахгүйгээр, чин сэтгэлээсээ ба маш зөвөөр үйлдэх нь, Мусульманчуудын ялгарах онцлог хэмээн Куран

сударт ойр ойрхон өгүүлдэг. Намаз мөргөлийг нийтээрээ үйлдэхийн төлөө масжид буюу сүмд очих нь Мусульманчуудын дунд нэг нэгэнтэйгээ танилцах, харилцах, ах дүүгийн ба тусламжийн харилцааг бэхжүүлдэг тул Гэгээн Элчийн зүгээс зарлигдсан.

Мусульман хүний үйлдэх ёстой нь, Расул-Акрам-Гэгээн Элчийн уриалга ба сургаалуудыг даган намаз мөргөлийн тухайд шаардлагатай ач холбогдлыг нь үзүүлэх хэрэгтэй. Ингэснээр хүн, амьдралын гүн гүнзгий ажил төрлийн дундуур өдөрт таван удаа завсарлагаа өгөн Агуу Аллах эзнийг санаж, Түүнд үзүүлэх хүндэтгэл болон хайр халамжаа илтгэн харуулдаг. Намаз мөргөлдөө бүхий л талаараа Рабб эзэн рүүгээ чиглэсэн албат, ариусан, тайвширч, амар амгаланг олж авах ба мөнхийн амьдралд ч аз жаргалд хүрдэг.

Намаз мөргөл үйлдэхийн тулд угаалга эсвэл бүтэн биеийн угаалга үйлдсэн хүн, материаллаг ба оюун санааны хирээс цэвэрлэгдэн ангижирдаг. Өмсөж зүүхдээ ч гэсэн анхаарал хандуулдаг. Тийнхүү намаз мөргөл үйлдэхдээ цэвэрхэн хувцаслах ба далдлан хаах шаардлагатай биеийн хэсгийг хаан далдлах хэрэгтэй байдаг. Дараа нь кибле чиглэн, нүүрэн талаараа кибле руу зүглэхдээ сэтгэлээ болохоор Рабб эзэн рүүгээ чиглүүлдэг. Кибле гэдэг нь Кабе буюу Мекке хотод оршдог. Кабе нь, Аллахын өргөө нь юм. Дэлхийн өнцөг булан бүрт байгаа Мусульманчууд нэг зүг рүү чиглэн ариун болон гайхалтай нэгэн цэгт цуглардаг.

Таван удаагийн мөргөл нь, Мусульман хүнд фарз буюу заавал биелүүлэх ёстой бөгөөд Аллахын зарлиг болгосон татгалзах боломжгүй нэгэн мөргөл залбирал юм. Өглөө, бага үд, их үд, орой ба шөнийн цагаар үйлдэгддэг «заавал үйлдэх мөргөл залбирлууд» өөр өөр рекат тоотой бөгөөд богинохон хэсгүүдээс бүрддэг. Түүний хажуугаар Гэгээн Элчийн өөртөө дадал зуршил болгосон ба мүминчүүдэд үлгэрлэх үүднээс үйлдэж байсан «сүннет намаз мөргөлүүд» ба хүн өөрөө хүссэн үедээ үйлдэж болдог «нафилэ намаз мөргөлүүд» байдаг.

Намаз мөргөлд бэлэн болсон хүн аль намаз мөргөлийг үйлдэхээ тодорхойлсноор эхлээд ниет буюу зорилгоо хэлэн, дараа нь гараа өргөх ба такбир авна. «Аллаху Акбар» (Аллах хамгийн агуу нь) гэж хэлснээр Аллахын оршихуйг, цор ганц, хамгийн агуу болохыг нь мөн Түүнээс өөр ямар ч оршихуйд мөргөн залбирах боломжгүй гэдгийг ухамсарлан намаз мөргөлөө эхэлдэг. Намаз мөргөлөө үйлдэж эхэлсэн үедээ бусадтай ярьдаггүй.

Такбирын дараа тэрээр гараа холбон (нэг гараараа нөгөө гарынхаа бугуйг барьж зогсох), Аллахын өмнө хэсэг хугацаанд хөл дээрээ босоогоороо зогсоно. Эхлээд «Субханака» хэмээн танигдсан дуга буюу залбирал уншлагыг уншина. Дуга уншлагын дараа Аллах эзэнд залбирал ба сүсэглэн дагах утгыг агуулсан «Фатиха Суре»-ээр үргэлжилдэг. Фатихаг уншиж дууссаны дараа «аамийн» гэх ба Куран-Каримаас сайн мэдэх суре бүлэг ба айлдваруудаас уншдаг.

Киямын (босоогоор зогсох) дараа такбир хэлж рукугт (бөхийх) очдог. Рукуг, Алладын агуу болон сүр жавхлангийн албат өөрийнхөө сул дорой гэдгээ хүлээн зөвшөөрч нуруугаа нугалах ба бөхийж буй хэлбэр юм. Рукуг үйлдэхдээ, хамгийн багадаа гурван удаа «Субхана Раббиял-азийм» (Машид агуу Рабб эзэн минь, бүх төрлийн дутагдлуудаас хол, ангид) гэж хэлдэг.

Рукугаас босохдоо «Самиг-аллаху лиман хамидах» (Аллах өөрт нь талархсаныг сонсдог) хэмээх ба «Раббана уа лакал-хамд» (Рабб эзэн минь бүх төрлийн талархал чиний төлөө) гэж хэлэн талархалаа илэрхийлдэг. Дараа нь такбир хэлэх ба сажда руу очно. Сажда гэдэг нь; гараа, нүүрээ, өвдгөө мөн хөлөө газарт тавьж, магнайгаа ба хамраа газарт наан хүргэж нүүрээрээ доош харан хэвтэж үйлддэг. Нэг рекагатад хоёр удаа үйлдэгдэх тус бүрт нь хамгийн багадаа гурван удаа «Субхана Раббиял-агла» (Хамгийн агуу болох Рабб эзэн минь бүх төрлийн дутагдлаас ангид хол) хэмээн хэлсэн хүн, хоёр саждагийн хооронд түр сууж хүлээдэг.

Энэхүү дарааллын дагуу үйлдсэн тус бүрийн намаз мөргөлийн хэсгийг «рекагат» гэж нэрлэдэг. Рекагатуудаа дуусгасны дараа намазын мөргөлийг төгсгөлд хэсэг хугацаанд сууж буй Мусульман, төрөл бүрийн дуга залбиралыг уншдаг. Ка’де-й ахире гэгдэх төгсгөлийн суултын үеэр “ат-Тахияту”, “Салли”, ба “Барик”, “Раббана” хэмээх дуга залбиралуудыг уншдаг. Төгсгөлд нь, “ас-Саламу алейкум уа рахматуллах! ” (Алладын мэнд болон энэрэл нь биднийг ивээг) хэмээн эхлээд баруун талдаа

дараа зүүн талдаа салам буюу мэндлэх үгийг хэлснээр намаз мөргөлөө дуусгавар болгоно. Салам буюу мэнд нь, хүний баруун ба зүүн талд байгаа тэнгэрлэг элч сахиусан тэнгэрүүдэд, хүн төрөлхтөнд, хорвоо дэлхийд энх тайван ба амар амгаланг хүсэх, чухамдаа намаз мөргөлөөр энэ ертөнцөөс өнгөрсөн хүнийг дахин энэ ертөнц рүү буцахыг дүрсэлдэг.

Намаз мөргөлийг, залхуурал, хайхрамжгүй ба үл тоох гэх мэт шалтгаануудын улмаас орхигдуулан, тасалдуулах мөн оройтуулах нь Мусульман хүнд тохирох шинж чанар биш юм. Учир нь намаз мөргөл, Ислам шашны үндсэн зарчмуудын нэг ба мөргөл залбирлын хамгийн тод харагдах үзүүлэлтүүдийн нэг юм.

Мацаг



*“Аяа, сүсэгтэн олон минь ээ! Мацаг барих
нь та нараас өмнөх ард түмэнд ариун
үүрэг (фарз) болгогдсоны адил та бүхэнд
ч гэсэн ариун үүрэг (фарз) болгогдсон.”⁶*

(Куран Карим)

Мацаг барих нь, үүр цайхаас нар жаргах хүртэл үргэлжилдэг зөвхөн Аллахын төлөө зориулан идэж, уух, бэлгийн харьцаанд орохгүй хол байхыг хэлнэ. Мацаг барих нь, намаз мөргөл, зекат өглөг, хаж мөргөл үйлдэхтэй адил ба бүх гэгээн элч нарын оролцоотойгоор хүн төрөлхтөнд үүрэг болгосон үндсэн мөргөл залбирлуудын нэг нь билээ.

Ислам шашны хувьд, мацаг залбирал нь, Рамазан сард буй, ухаан санаа нь эрүүл ба насанд хүрсэн Мусульман хүн бүрт фарз буюу заавал биелүүлэх хэрэгтэй нэгэн үүрэг юм. Өвчтөй буюу аян замд яваа, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд Рамазан сарын мацгаа өөр нэг цаг хугацаанд барьж, мацгаа нөхөж барьж болно. Наснаасаа үл хамааран эмчлэгдэх боломжгүй хүнд өвчтэй

6 Бакара, 2/183.

ба мацаг барих боломжгүй өндөр настангуудын хувьд дараа нь нөхөж барих боломжгүй бол «фидье» төлдөг. Фидье гэдэг нь барьж амжаагүй Рамазан сарын мацгийн өдөр бүрийн төлөө ядуу өлсгөлөн хүнийг цатгах хэмжээнд мөнгөн төлбөр төлөхийг хэлнэ. Мөнгө төгрөгний боломжгүй хэн нэгэн Аллагаас өршөөл, уучлал эрнэ. Эцэст нь Аллах үнэн шударга ба фидье, мацгийн оролцоотойгоор нийгмийн харилцааг идэвхтэй болгох зорилготой нэгэн төлбөр бөгөөд, мацгийн үнэ цэнэ нь эд материалаар хэмжигдэхгүй юм.

Ислам шашин нь, Рамазан сарын өдрүүдээс бусад үед ч гэсэн мацаг барихыг уриалсан. Рамазан сарын дараа ирэх Шаууал сар дотор зургаан өдөр мацаг барих, долоо хоногийн Даваа ба Пүрэв гаригт, сарны тооллоор сар бүрийн арван гурван, арван дөрөв ба арван таванд мацаг барих нь Гэгээн элч (с.а.у)-ын зүгээс онцгой ач холбогдол өгсөн. Гэгээн элч үүнээс гадна Мухаррем сарын арав дахь өдөр болох Ашуре өдөр мөн тус өдрөөс нэг өдрийн өмнө ба нэг өдрийн дараа мацаг барих нь буян хишиг арвинтай болохыг айлдсан.

Ислам шашны хувьд мацаг барихыг зөвлөдөг өдрүүд байдгийн адилаар мацаг барихыг хориглодог өдрүүд ч гэсэн байдаг. Рамазан баярын эхний өдөр ба Курбан баярын эхний дөрвөн өдөр мацаг барихыг хориглодог. Учир нь энэ өдрүүд нь муминчүүдийн хувьд баярын өдөр юм. Мөн долоо хоногийн баярын өдөр хэмээгддэг Баасан гаригт өмнө нь буюу дараа нь барих мацаг байхгүй тохиолдолд тус өдөр мацаг барихыг зохимжгүй хэмээн үздэг.

Мацаг барихын тулд Мусульман хүн зөвхөн ходоодоороо бус, бүтэн бие организмаараа мацаг барих хэрэгтэй. Нүдээрээ сайн сайхныг харан муу муухай руу үл харах, чихээрээ сайн зүйлийг сонсон хар барааныг үл сонсох, хэлээрээ ба сайн буюу буянтай үгнүүд хэлэх эсвэл дуугүй байх, зүрх сэтгэлээрээ сайн сайхныг бодон саар бодол хүслүүдээс холуур байх хэрэгтэй. Худал, хов жив ба хуурмагийг орхиогүй хэн нэгний мацаг барих нэрийдлээр хоосон ходоод байх нь Аллахын хувьд шаардлагатай биш юм.

Мацаг барих нь, хүнийг хязгааргүй хүслүүдээс, дуусахгүй шунал тачаалаас хамгаалахад сургадаг. Түүнд тэвчээр, талархал, даатгал, буян хишгийн үнэ цэнийг болон эрүүл байхын ач тусыг сургадаг. Бие лагшинд нь эрүүл энхийг, оюун ухаанд нь гавшгайг, зүрх сэтгэлд нь тайван амгаланг өгдөг. Сахур буюу мацаг барих хугацаа эхлэхээс өмнө хооллосноор цаг хугацааны ухамсарт, ифтар буюу мацгийн ширээндээ нэн шаардлагатай хүмүүстэй учран садака өглөгийн элбэг дэлбэг байдалд хүрэхийг нь хангаж өгдөг.

Зекет ба Садака (Өглөг)



*“Наминчлан залбирч, сайн үйлс хийвэл, уншлага
мөргөлөө гүйцэтгэн, ариуслын өглөг өгвөл
Аллахын талархал, шагналыг хүлээх болно.*

Тэдэнд айдас хүйдэс үгүй. Тэдэнд уй гашуу үгүй.”⁷

(Куран Карим)

Хүмүүст туслах, тусламж шаардлагатай нэгэнд тусламж үзүүлэх ба нийгмийн сул дорой хэсгийг чадавхжуулах, Мусульман хүний ёс суртахууны онцлог шинж чанаруудын нэг юм. Энэхүү сайн үйлийн бүтэц болгон хувиргах нь Ислам шашны зекат (өглөг) системээр бий болдог.

Зекат өглөг нь, Исламын таван үндсэн зарчмуудын нэг юм. Шашны үүднээс баянд тооцогдох нэг Мусульманы, өөрийн эд хөрөнгөнөөс тодорхой нэг хэсгийг нь, зөвхөн Аллахын талархлын төлөө, Куран-Каримийн зүгээс тодорхойлогдсон нэн шаардлагатай хэсэг бүлэгт тарааж өгдөг. Алт, мөнгө, худалдаа наймааны эд хөрөнгө, газар тариалан ба мал

7 Бакара, 2/277.

амьтад гэх мэт үр өгөөжөө өгдөг зүйлүүдээс зекат (өглөг) өгдөг.

Зекат эд хөрөнгийг багасгах бус, эсрэгээр ариусахад нь, олшрох ба ахиретийн (нөгөө ертөнц) шагнал болон хувирахад нь нөлөөлдөг. Куран сударт, муминчүүдийн онцлог шинжүүдийг тоочихдоо ихэнх айлдваруудад намаз мөргөлийг бүрэн гүйцэт үйлдэх ба зекат (өглөг) өгөхийг дарааллан айлддаг. Энэхүү айлдварууд нь, бие организм болон эд хөрөнгөөрөө Аллахад мөргөл залбирал үйлдсэнээр бүхий оршихуйгаа Түүнд зориулсан хүний дүр төрхийг дүрслэн харуулдаг.

Исламын хувьд, баян хүн зекат өгөх шаардлагатайгаас гадна, баян болон ядуу ялгаагүй хэн бүхэн «садака» (өглөг) сайн дураараа өгөх буюу нэг дутуугаа нөхөн сэтгэлээсээ хандив өргөн хэн нэгнийг баярлуулж болно. Садака (өглөгийн) ямар нэг хязгаар, орон зай болон цаг хугацаагаар хязгаарлагддаггүй. Материаллаг болон сэтгэл санааны үүднээс үйлдсэн бүх төрлийн сайн үйл нь садака (өглөг) хэмээн тооцогддог.

Өлсгөлөн байгаа хэн нэгнийг хооллон цатгах нь садака (өглөг) бол, өвчтөй байгаа хэн нэгнийг эргэж очих нь ч гэсэн садака (өглөг) юм. Хэн нэгэн аав гэртээ хоол хүнсээ цуглуулах нь тус хүнсээр гэрийн эзэгтэй хоол хийж гэр бүлээ цатгах нь ч гэсэн садака (өглөг) юм. Нэгэн сайн үг, чин сэтгэлийн сургааль, инээмсэглэсэн царай төрх, сайн сайханд уриалан саар зүйлээс хамгаалах, замд яваа нэгэн ба зочноо дайлах,

ахмад хүний ачааг үүрэх, амьтадыг хайрлан хамгаалах, мэдлэгээ хуваалцах ба бусад олон сайхан үйлдлүүд садака (өглөг) төрөлд багтдаг.

Агуу Аллах, итгэсэн-итгээгүй хэлбэрээр нь ялгаварлахгүйгээр, хүн бүрт эд хөрөнгө өгдөг. Гэвч хэн нэгэн хүн эд хөрөнгийн эзэн болох нь, түүний хүндтэй нэгэн гэдгийг илэрхийлдэггүй. Эд хөрөнгийн эзнийг хүндтэй болгодог зүйл нь, гартаа байгаа буян хишгийн үнэ цэнийг мэдэх ба талархлыг нь биелүүлэх хэрэгтэй. Эд хөрөнгийн талархал нь, нэн түрүүнд эд хөрөнгийн жинхэнэ эзэн Аллах гэдэгт итгэх ба тэрхүү эд хөрөнгөнд нь нэн шаардлагатай ядуу хүмүүсийн ч гэсэн эрх байдгийг ухааран түүнийг биелүүлэх явдал юм.

Ислам шашин нь өмч хөрөнгийн эзэн болохыг, эд хөрөнгө хураахыг сөргөөр хүлээн авч үздэггүй. Учир нь чинээлэг мүмин, гартаа байгаа материаллаг хөрөнгөө сайн үйлд зориулваас өөрөө хожих ба нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулдаг. Ислам шашны хувьд эд хөрөнгийн хамгийн муухай нь бол, нэн шаардлагатай ядуугийн хувь хишгийг анхааралгүйгээр шуналтайгаар цуглуулсан ба харамч сэтгэлээр хураасан хөрөнгө юм.

Зекат болон садакад ач холбогдол өгөхийн хамтаар өөр нэгэн сэдэв нь даруу төлөв байдал ба нууцлаг байдлаар өгөх юм. Ядуусыг гомдоох, тусалж буй тусламжаа ихэрхэн өгөх, хандивлаж буй хандиваа рекламдах нь хэзээ ч хүлээн зөвшөөрөгддөггүй.

Хүн эд хөрөнгөөрөө болох туршилтанд амжилттай давах нь, зөвхөн эд хөрөнгөө гэсэн сэтгэлээ хяналтандаа авснаар бусад хүмүүсийг ч гэсэн анхааралдаа авснаар туршилтыг давах боломжтой. Хүн, зекат ба садака (өглөг) өгснөөр харамч байдлаас, эд зүйлийн ба ашгийн төлөө боолчлогдохоос сэргийлж чаддаг. Хуваалцахын амтыг мэдрэн өгөөмөр сэтгэлд дасан зохицдог. ‘Би’ сэтгэлгээгээ нэг мухарт үлдээн, ‘бид ’ гэсэн мэдрэмжийн үнэ цэнийг ойлгодог.

Энэ хорвоо, доторх бүх сайн сайхан ба баялгуудын хамтаар түр зуурынх юм. Үүрдийн зүйл нь иман (итгэл) ба сайн үйл буюу сайн сайхны төлөө хийсэн хөрөнгө оруулалт юм. Хүн түр орлон итгэмжлэгч юм. Жинхэнэ баялаг бол, сэтгэлээсээ өгөн зекатаар нэг хүний амьдралд хувь нэмрээ оруулан; садака (өглөг)-аар сургууль соёл, масжид буюу сүм хийд, ундны ус түгээх газар, мэдлэгээ хуваалцан хүнийг хөгжүүлсэн хүн юм.

Хаж мөргөл



*“Бололцоотой хүмүүс Аллахын төлөө Кагба-д
хаж ёсны мөргөл үйлдэх нь ариун үүрэг мөн.”⁸*

(Куран Карим)

Ислам шашны хувьд, хүмүүсийн төлөө анхны мөргөл залбирлын байр нь, Меккед хорвоо ертөнцөд энэрэл ба дардан замын эх булаг хэмээн баригдсан Кабе юм. Хаж мөргөл гэдэг ихрамыг өмссөнөөр (хаж мөргөлийн үед өмсдөг хувцас) Зилхижже сарын ес дэх өдөр болох Арафе өдөр Арафат ёслолд зогсох, дараан нь Кабег тойрон эргэхийг хэлнэ. Ингэж Кабег тойрч эргэснээрээ Аллах руу чиглэдэг. Хаж мөргөл нь жилд нэг удаа болдог, тодорхой өдрүүдэд ба Кабегийн оршдог Харемийн орон зайд явагддаг.

Мекке рүү хийсэн ариун аяллаараа Мүмин хүн өдөрт таван удаа намаз мөргөл үйлдэхдээ холоос чиглэдэг Аллахын орон байрыг энэ удаадаа хажуунаас харж, мэдрэх боломж олддог. Мэдээжийн хэрэг хаж мөргөлд жинхэнэ

8 Али-Имран, 3/97.

зорилго нь Кабед очихдоо гол нь биш юм. Гол зорилго нь, Кабегийн эзэн Аллахын талархалыг хүлээх, Түүний төлөө гэсэн харилцаа холбоо, дуулгавартайгаар хандах хандлага, сүсэглэн дагах ба хягзааргүй талархлаа илэрхийлэх явдал юм.

Хаж мөргөл нь, эд хөрөнгө ба бие организмараа биелүүлдэг нэгэн мөргөл залбирал бөгөөд тусгай нэгэн орон зай онцгой байр суурийг эзэлдэг. Мусульманчуудын сэтгэл санааны зүг чигийг бэхжүүлдэг, тэдэнд эв нэгдэл хамтын хүчийг ойлгуулдаг, хүндлэл ба хариуцлагыг нэмэгдүүлдэг, үммет бөгөөд хамтын хүчээр хөдлөх ухамсарыг бий болгож өгдөг. Хаж мөргөлийн ариун уур амьсгалд үндэс угсаа, хэл яриа, өнгө төрх, соёлууд өөр өөр гэвч шашин нэг Мусульманчууд, хайр энэрэл, мэдлэг мэдээлэл, ёс зүй, туршлага ба соёлын солилцоог хийж, нэг нэгнээсээ мэдээлэлтэй болох боломжийг олж авдаг. Ингэснээр, хамгийн ариун цаг хугацаанд, хамгийн ариун газарт хүртээмж буян хишиг арвинтай нэгэн цугларалт болдог. Тиймээс хаж мөргөл нь зөвхөн хувь хүний бус, түүний нийгэм олон нийтийн хувьд ч гэсэн өргөн цар хүрээтэй хүртээмжүүд байдаг.

Хаж мөргөл нь, бэлгэдлүүдээр дамждаг нэгэн мөргөл залбирал юм. Хаж мөргөлийн үед хийгддэг үйлдэл бүрийн, үйл хөдлөл бүрийн бэлгэдэл бүхий утга агуулдаг. Гэгээн элч Ибрахимийн гэр бүлд болсон ихэнх тохиолдол, түүний хүү Исмайл ба түүний эхнэр Хажерт тохиолдсон явдлуудыг бэлгэдэл болгон үйлддэг ба дахин үйлдэгддэг. Кабегийн эргэн тойронд

тауаф, Сафа ба Маруагийн хооронд сай, ихрам, телбие, үсээ засуулах, Арафатад зогсох, шайтан руу чулуу шидэх ба курбан төхөөрөх гэх мэт үйлдлүүд нь хаж мөргөлийн нэг хэсэг ба Гэгээн Ибрахимээс Гэгээн элч Мухаммед (с.а.у) хүртэлх элчүүдийн өв уламжлал нь юм.

Аллахын элч (с.а.у) өөрийн хүсэл ба шунал тачаалаа орхин, нүгэл болон муу муухайгаас холуур байн хаж мөргөлөө гүйцэтгэсэн хэн нэгэн, эхээс төрсөн мэт цэвэр ариун болдгийг дуулгасан. Түүний хэлснээр, *"Аллахын зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн хаж мөргөлийн шагнал нь зөвхөн диваажин юм."*⁹

9 Бухари, Мухсар, 10; Умре, 1.

Курбан



*“(Курбаны) Мэдээж тэдний мах, цус
нь Аллахад эс очмуй. Гагцхүү Түүнд
та нарын чин сүсэглэл нь очмуй.”¹⁰*

(Куран Карим)

Курбан, Агуу Аллахад мөргөл залбирал үйлдэх зорилгоор, тодорхой нэгэн цаг хугацаанд, тодорхой шаардлагуудыг хангасан мал амьтдыг зохих ёсоор төхөөрөх юм. Бүх мөргөл залбирлуудын адилаар, курбанд ч гэсэн гол зорилго Аллахад ойртох ба Түүний талархлыг хүлээх юм. Тиймээс курбан, Аллахын өмнөх үүргээ ухамсарлах дуулгавартай албатын, Түүнд хүргэх нэгэн хүндлэл ба сүсэглэн залбирахын илэрхийлэл юм.

Курбан нь Гэгээн Адамаас эхтэй тухайн нийгмийн хүн бүрд айлдсан нэгэн мөргөл залбирал юм. Мусульманчууд өнөөдөр ч гэсэн курбанаа төхөөрөхдөө, Аллахын төлөө зориулсан курбанаараа чин сэтгэлийн туршилтад орсон Гэгээн Адамын хоёр хүүхэд Хабил ба Кабилийг

10 Хаж, 22/37.

санан дурсдаг. Энэ туршилтад Алладын тушаалыг хамгийн сайн хэлбэрээр дагасан Хабил даван туулж, атаархуу ба харамч Кабил ялагдсан.

Курбан төхөөрөх нь үүний зэрэгцээ Гэгээн Ибрахим ба түүний хүү Исмайлйн сүсэглэн дагасан туршилтыг мөн сануулдаг. Ганц хүү Исмайлыгаа курбанд төхөөрөхөөр андгайлан Гэгээн Ибрахим, Алладын төлөө хамгийн үнэ цэнтэй оршихуйгаа золиослох чадвартай гэдгээ харуулснаар, нэгэн хониор мялаалгасан.

Исламын элч Гэгээн Мухаммед (с.а.у) нас барах хүртлээ жил бүр курбан төхөөрч (тахил өргөх), төхөөрсөн малынхаа махнаас өөрөө ба гэр бүл нь идэн, найз нөхдөдөө зоог барин, бас хоосон ядуу хүмүүст ч гэсэн тарааж өгсөн.

Курбан гэгдэхээр Курбан баярын үеэр төхөөрсөн мал амьтад ойлгогддог хэдий ч жилийн бусад хугацаанд ч гэсэн мөргөл залбирлын зорилготой төхөөрсөн адак (ам, тангараг өргөсөн), шүкир (талархал), каффарат (өршөөл) ба акика (хүүхэд төрсөн үед) гэх мэт курбаны (тахил) төрлүүд байдаг. Тэдгээрийн махнаас хэрэглэх янз бүрийн шашны заалтууд байдаг.

Курбан мөргөлийн утгыг, Гэгээн Элч энэхүү үгэндээ ийн хураангуйлсан мэт: *“Би ханиф (Аллах эзэнд чиглэсэн) бөгөөд, нүүр царайгаа тэнгэр газрыг бүтээсэн Аллах руу чиглүүлсэн ба би мушрикүүдээс биш болно. Эргэлзээгүй миний намаз мөргөл, курбан (тахил), миний амьдрал ба үхэл ертөнц дэлхийн Рабб эзэн болсон Алладын төлөө*

*юм. Түүнтэй эн зэрэгцэх үгүй билээ. Би үүгээрээ айлдагдсан ба би Мусульманчуудын анхных нь юм. Аяа Аллах эзэн минь энэ курбан (тахил) чинийх ба Мухаммедын дагагсдын зүгээс чиний төлөө өргөн барьсан.*¹¹

Курбан төхөөрсөн Мусульман, Рабб эзнийхээ айлдварыг дагах, хайрласан буян хишгийг нь түүний төлөө зарцуулах ба ариусах зорилгоор энэхүү мөргөл залбирлыг биелүүлдэг. Эд хөрөнгийн шунал ба харамч байдлаас өөрийгөө хамгаалан, Аллахын төлөө сайн сайхан ба инфак (Аллахын төлөө зарцуулах) үйлдэн аз жаргалыг мэдэрдэг. Хамгийн ойрхон төрөл садансгаасаа эхлээд, нэн шаардлагатай, хохирогч, өнчин хэн нэгний нүүрэнд инээмсэглэл тодруулдаг. Ингэснээрээ курбан, (тахил өргөх) Мусульманчуудын хорон дахь ах дүүгийн, тусламж ба эв нэгдлийн харилцааг амьд байлган, нийгмийн шударга байдал оршин тогтноход хувь нэмрээ оруулдаг.

11 Абу Давуд, Дахаяа, 3-4.

Дуга



*“Боолууд минь та нараас Миний тухай асуувал:
Би тэдэнд ойрхон байна. Бас надад наманчлан
залбирах аваас түүний залбирлыг хүлээн авч
соёрхоно. Тэд зөв замаар явна гэвэл Миний
урилгыг хүлээж авагтун, надад итгэцгээгтүн.”¹²*

(Куран-Карим)

Дуга; (залбирлын) албат чин сэтгэлээсээ Аллахад залбиран сүсэглэх, Аллахын агуу чанарын өмнө сул дорой гэдгээ хүлээн зөвшөөрөх, Түүний төлөөх чин сэтгэлийн хайр ба хүндлэлээ илэрхийлж буян хишиг ба тусламж болон өршөөл эрэхийг нь хэлнэ.

Дуга (залбиралын) олон утгын дотор нь Аллах эзэндээ талархах, Түүнийг магтах, Түүнтэй адил ба эн зэрэгцэх оршихуй үгүй болохыг хэлэх, муу муухайгаас хамгаалах ба өршөөл эрэх, хэрэгцээтэй байгаа буян хишгийн төлөө залбирах гэх өөр өөр хүсэл ба бодлууд оршдог.

Дуга (залбирал), хэлбэр болон шаардалагаар хязгаарлагдахгүй, тодорхой нэг цаг хугацаа ба

12 Бакара, 2/186.

орон байр шаардахгүйгээр нэгэн амьдралын турш, өргөн хүрээтэй мөргөл залбирал юм. Мэдээжийн хэрэг ариун шөнүүд, фарз намаз мөргөлийн дараа, Жума мөргөлийн цаг, Арафа өдөр гэх мэт дуга (залбирал) хүлээн зөвшөөрөгддөг цаг хугацаанууд байдаг. Үүний зэрэгцээ, Мекке, Кабе, Арафат, Мадина гэх мэт дуга (залбирал)-аар нэгддэг газрууд ч гэсэн бий. Гэхдээ хүн, ямар ч цаг хугацаанд ямар ч нөхцөлд Рабб эзэндээ залбиран дуга үйлддэг нь, маргаангүй нэгэн үнэн юм.

Дуга (залбирал), Аллах ба албатын дунд нь үүсдэг харилцаа юм. Хүн, амьдралынхаа турш давж гарахааргүй маш олон асаудлуудтай тулгардаг. Уур хилэн, уй гашуу, зовлон, айдас, сул дорой байдал, ганцаардал, арга замгүй, өвчин эмгэг, ядуу тарчиг, горьдлого тасрах гэх мэт төлөв байдлууд тохиолддог. Ялангуяа хэцүү бэрх цаг хугацаанд Аллахад залбирах шаардалага гардаг. Тэрбээр эцэс төгсгөлгүй хүч чадлын эзэн Аллахын өөрт нь туслана гэсэн горьдлого, хүний уй гашууг хөнгөрүүлэх ба тэсвэрлэх хүчийг нэмэгдүүлдэг. Гэхдээ Агуу Аллах, хүмүүсийг зөвхөн хүндрэл бэрхшээлд орсон үед бус дуга залбирал үйлдэхийг хүсдэггүй. Тэр, байхгүй болон байгаа үед ч гэсэн, зовлон зүдгүүртэй ба тайван амгалан аз жаргалтай үед ч өөрийг нь санан дурсахыг хүсдэг. Хүнд бэрх үедээ залбирч боломжинд хүрсэн үед Түүнийг умартан, үнэнч сэтгэл ба ач тусыг мэддэггүй албатуудыг Куран судар зэмлэлээр өгүүлдэг.

Мусульман, амьдралдаа дуга (залбирал)-аар утга учиртай болгох болон нэр хүндийг

олж авдаг. Рабб эзэн нь үргэлж өөрийг нь харж буйг болон сонсож байдгийг ухамсарласан хүн дуга (залбирал)-гүй үлддэггүй. Дуга үйлдэхдээ яарч болохгүй, дуга залбиралаа хүлээн зөвшөөрөгдөнө гэх найдлагаа тасалж болохгүй. Зөвхөн өөртөө бус мумин ахан дүүстээ дуга залбирал үйлдэх нь хувиа хичээхээс хамгаалдаг. Чин сэтгэлээсээ залбирах ба Аллахаас хамгийн сайныг нь хүсэхдээ анхаарал хандуулдаг.

—❧—
ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХҮМҮҮЖИЛ
ТӨЛӨВШЛИЙН
ЗАРЧМУУД
—❧—

Ислам, Сайн Сайхан Төлөвшил Ёс суртахууны Шашин



*“Мүминчүүдийн иманы хувьд хамгийн
төгс нь, хүмүүжил төлөвшлийн
хувьд хамгийн төгс нь юм.”¹
(Гэгээн Мухаммед^(с.а.у))*

Хүмүүжил төлөвшил нь, хүн зөвхөн хүмүүстэй харилцах харилцаанд бус, Рабб эзэнтэйгээ, бусад амьд ертөнц ба хүрээлэн буй орчинтойгоо харилцах харилцаанд ч гэсэн эс татгалзах нэгэн тулгуур нь юм. Таухидийн шашин болох Ислам шашны хамгийн онцлог шинж чанаруудын нэг нь ёс зүй хүмүүжил төлөвшлийн зарчмуудад өгч буй ач холбогдол юм. Ислам шашны, үндсэн зорилго нь иман буюу Аллахад итгэдэг ба итгэлийнхээ дагуу хүмүүжил төлөвшилтэй хүмүүсээс бүрдсэн эрүүл нэгэн нийгэм ба тайван амгалан дэлхийг бүтээх явдал юм.

Элчийн үүрэг хүлээхээс өмнө ч гэсэн хүмүүжил төлөвлөөрөө танигдсан ба Меккед “Итгэлт Мухаммед” хэмээгдсэн Гэгээн элч (с.а.у) “Би

1 Абу Давуд, Сунна, 15.

сайн сайхан хүмүүжил төлөвшлийг төгс болгохын тулд илгээгдсэн”² айлдсан. Түүний элчийн үүргээ хүлээсэн анхны өдрөөс эхлэн иманы (итгэл, сүсэг бишрэл) зарчмуудын хамтаар хүмүүжил төлөвшлийн зарчмыг хүмүүст хүргэн, Исламын шашинд иман-хүмүүжил төлөвшлийн холбоог хэрхэн хүчтэй холбож байсныг харуулдаг.

Исламын шашин нь, амьдралынхаа хором бүрд бүхий л салбарт хүмүүжил төлөвшлийг амилуулан оршихыг хүсдэг. Учир нь Аллах эзэнд ойр байх болон Түүний талархлыг хүлээх зам нь, хүмүүстэй эелдэг зөөлнөөр харьцах ба хүмүүжил төлөвшлийг алдагдуулахгүй байхаас үүдэлтэй. Тийнхүү, Гэгээн элчийн ихэнх хадисуудад (үг, сургаал) хэлсэнчлэн, хэн хүмүүст хайр энэрлээр хандвал Аллах түүнд хайр энэрэлээр ханддаг; хэн хүмүүсийг уучлан нууцыг задруулахгүй байвал Аллах ч гэсэн түүнийг уучлах ба хамгаалан; хүмүүст зоог барьсан нэгэнд Аллах ч гэсэн буян хишгээ хүртээдэг; хэцүү байдалд орсон хэн нэгэнд тусалсан хүнийг Аллах ганцаарыг нь болон тусламжгүйгээр орхидоггүй. Гэхдээ хүмүүсийг дарамталж, эрхийг нь булаасан, алдааг нь илчилсэн, зочин, хол замын аянд яваа, хамаатан саднаасаа харамласан хүнийг ч гэсэн Аллахын зүгээс мөн адил шийтгэдэг. Тиймээс Исламын шашны дагуу сайн хүмүүжил төлөвшил бол зөвхөн хувийн харилцааг биш, мөн энэ нь албат болон Аллах хоёрын хоорондын харилцаанд хамааралтай бөгөөд хэлбэржүүлдэг.

2 Ибн Ханбел, II, 381.

Мусульман хүн зан чанар, шударга үнэн, хайр энэрэл, Бүтээгчийн ачаар бүтээгдсэнийг хайр болон хүндлэлээр хандах, даруу төлөв байдал, өгөөмөр, итгэлтэй, үнэн үгтэй, хичээнгүй, зочломтгой, эв нэгдэл ба тусламтгай зэрэг чанаруудыг өөртөө агуулдаг. Ислам шашны хувьд, хүнийг энэ ертөнц болон хойд ертөнцөд аз жаргалтай болгодог иман (итгэл) нь, сайн хүмүүжил төлөвшил ба чин сэтгэлийн мөргөл залбирал юм.

Ислам, Шударга Үнэний Шашин



*“Эргэлзээгүй, Аллах та нарт шударга
байхыг, сайн үйл хийхийг, ах дүү хамаатан
садандаа туслахыг зарлигдмуй. Харин ичгүүр
сонжуургүй, садар самуун, ад үзэгдэх явдал,
хүчирхийллийг бүрэн хориглоно. Та нарыг
сургамж аваг хэмээн ийн ухуулан сэнхрүүлнэ.”³*

(Куран-Карим)

Шударга ёс; сайн үйл хийсэн нэгэн зохих шан харамжийг нь, хэрэг үйлдсэн нэгэнд зохих шийтгэлийг нь өгөхийг хэлнэ. Шаардлага хангасан нэгэнд зохих үүргийг ба ажилчинд дуслуулсан хөлснийх нь шан харамжийг өгөх; хүмүүсийн дунд хүн чанар, эрх тэгш байдал ба тэнцвэрийг хадгалах нь ч гэсэн шударга ёс юм. Шударга ёсны доор, хүний алдар нэр, нэр хүнд ба эрх үүргүүд нь мөн нийгмийн амар амгалан ба дэг журам хадгалагдаж байдаг.

Агуу Аллахын нэг нэршил нь “ал-Адл” буюу “Мөнхийн ба ганхашгүй шударга ёсны эзэн” юм. Энэ ертөнц дэлхийг нэгэн тэнцвэрт байдал дээр бий болгосон, хамгийн жижиг сайн үйл, хамгийн жижиг муу үйлийн үрийг ч гэсэн хариуг дутаахгүйгээр өгдөг, албатуудын хооронд үргэлж шударга ёсыг сахидаг Тэр юм. Энэ ертөнц дээр хүмүүсийн дунд зарим буян хишгүүд нь эн тэнцүү тараагдаагүй ба зарим хүндрэл бэрхшээлүүд адил тэгш бүтээгдээгүй мэт харагдсан ч чухамдаа энэ ертөнц болоод нөгөө ертөнцийн хамтаар мөнхийн буюу хязгааргүйд хүрэх нэгэн хугацаа хэмээн авч үзэх нь чухал юм. Учир нь Аллах эзэн, хүн бүрийг өөр өөр сорилтод сорин ахирет буюу нөгөө ертөнцөд түүнтэй нь уялдуулан шан харамжийг нь өгөн шударга ёсыг туйлын хэмжээгээр хангах болно.

Аллах эзэн, албатууддаа удирдах, шүүх болон бүх хүмүүсийн харилцаанд шударга ёсны шалгуурт нийцүүлэн ажиллахыг шаарддаг. Шударга ёсны эсрэг утгыг илтгэх дарангуйллыг хатуу хориглодог. Ислам шашны хувьд бүхий л хүмүүс, үндэс угсаа, нийгмийн давхарга, өнгө зүс, хэл яриа, шашин ба хүйсийг харгалзахгүйгээр хуулийн өмнө бүгд эрх тэгш юм. Аллахын өмнө давуу байдлыг үүсгэх ганц зам нь, Түүний өмнө маш хариуцлагатай ухамсартайгаар харьцах болон Таква (Аллахаас эмээх)-ийн эзэн болох хэрэгтэй.

Ислам нь хүн бүрийн амь нас, эд хөрөнгө, ариун явдал, итгэл үнэмшил ба оюун ухааныг халдашгүй гэж үздэг. Мөн Агуу Аллах,

Мусульманчуудыг дайсныхаа эсрэг ч гэсэн шударга хандахыг уриалдаг: *“Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын төлөө шударгаар гэрч бологтун. Аль нэгэн ард олонд санасан өс хонзон чинь шударга зарчмаас гажиж болохгүй. Шударга байгтун. Энэ нь үнэн сүсэглэл, саруул ухаанд ойр зүйл. Аллахаас айгтун. Аллах үнэндээ та нарын юу хийснийг бүрэн мэднэ.”*⁴

Шударга ёс, нийгмийг тэтгэж, хүмүүст итгэл төрүүлдэг ёс суртахууны хамгийн чухал үнэт зүйл нь юм. Шударга ёсыг эс сахиваас дарангуйлал, шударга бус байдал, найдваргүй байдал, үймээн самуун ба хэрүүл маргаан нийгмийг хамардаг. Тиймээс хувь эзэмшигч бүрд хувийг нь өгөх, хамт амьдрах эсвэл тушаал ба үүрэг хариуцлага дор байгаа хүн бүрийн эрхийг хүндэтгэх, Мусульман байхын шаардлага юм. Эцэг-эх хүүхдүүдийнхээ хооронд шударга хандахыг, удирдагчийн шударга ёсноос огтхон ч хазайхгүй, шүүгч нь шударга ёсоор шүүх, нийгэмд эмэгтэй ба эрэгтэй гишүүдийн хооронд шударга ёсыг бий болгох, ажил олгогч нь ажилтандаа тав тухыг нь шударгаар хангах хангах нь Ислам шашин нь үүрэг болгодог.

4 Майда, 5/8.

Ислам, Эв Нэгдэл ба Энх Тайвны Шашин



*“Аяа, сүсэгтнүүд минь ээ! Нийтээрээ
Энх тайванд (Исламд) орогтун.”⁵
(Куран- Карим)*

Ислам шашны, нэр нь “салам” буюу “энх тайван, эв нэгдэл ба аврал” гэсэн язгуураас гаралтай. “ас-Салам” үүний зэрэгцээ Агуу Аллахын нэг нэр бөгөөд “энх тайван, эв нэгдэл ба аврал руу хөтлөх” гэсэн утгуудыг агуулдаг. Мусульман хүн бол “энх тайван ба эв нэгдлийг сонгосон” нэгэн юм. “Иман” ч гэсэн үүний зэрэгцээ “өөрийгөө тайван амгалан ба аз жаргалаар дүүрэн мэдрэх, айдсаас ангижрах” гэсэн утгатай. Тиймээс үймээн самуун, мөргөлдөөн, терроризм ба дайныг Исламын мөн чанар, түүний илгээгдсэн зорилго, оршин тогтнох зарчимтай огтхон ч хамааралгүй юм.

Исламын шашин, эх дэлхийд амар амгаланг, эв нэгдлийг, харилцан хүндлэлийг ба аюулгүй

5 Бакара, 2/208.

орон зайг бий болгохыг зорьдог. Оюун ухаан шиг нэгэн буян хишигт эзэн хүн төрөлхтнийг, хэрүүл маргаанаа дуусган эвлэлдэн нэгдэхийг уриалдаг.

Мусульман хүн амьжиргаатай, амар амгалан ба эвлэрэлд ойрхон, сайн ёс суртахуунтай төлөвшсөн зан чанарыг, Рабб Эзнээсээ хүлээн авдаг. Түүнд бууж өгснөөр амар амгалангийн ба эх булагтай нь холбогдоно. Өөрийнхөө дотоод ертөнцөд аз жаргал ба тайван амгалан байдалд хүрсний адил, энэхүү аз жаргалаа гадаад ертөнц рүү ч гэсэн чиглүүлдэг. Аллахын хүн төрөлхтөнд шулуун дардан замын хөтөч болгон илгээсэн Куран ба энх тайвны хамгийн том төлөөлөгч Гэгээн Мухаммед (с.а.у)-ыг дагаснаар “дару’с-салам” буюу “энх тайвны орон” хэмээн нэрлэгдсэн диваажинд хүрдэг.

Хүн төрөлхтний түүх нь Гэгээн Адамын хүүхдүүдийн дунд болсон анхны муухай үйлдлээс энэ хүртэлх, маш олон дайн тулаан, аюул гамшиг, дарангуйллын гэрч болсон. Итгэл бишрэл, өнгө зүс, үндэс угсаа ба амьдарч буй газарзүйн байрлал эзэмшиж байгаа эд хөрөнгөнөөсөө хамааран маш олон хүмүүсийн эрх нь зөрчигдөж, нэр хүнд нь буурсан ба хамгийн үндсэн эрх болох амьд явах эрхийг үгүй хийсэн. Гэвч түүхийн турш Агуу Аллах эзэн, хүмүүсийг анхааруулсан, хүн төрөлхтөнд зохистой нэгэн амьдралыг мөн хүмүүст өргөн барихын тулд элч нар ба судрууд илгээсэн. Элч нарын гинжин хэлхээний сүүлчийн холбоос болох Исламын Элч Мухаммед Мустафа (с.а.у)-аар оргилдоо хүрсэн.

Исламын элч, амьдралынхаа турш харилцсан хүмүүстэйгээ үнэн ба шулуун дардан зам руу урин дуудаж, энх тайван ба эвлэрлийн талд зогсдог байв. Исламын нэр хүнд ба хүн төрөлхтний үнэт зүйлд, Мусульманчуудын эрх болон халдашгүй зүйлүүдэд гар хүрэхгүй аваас огтхон ч буу зэвсэг рүү ойртоогүй. Энэ талаар Куран сударт ийн өгүүлсэн: *“Аллах та нартай шашны тухайд үл дайтсан, та нарыг эх нутгаас чинь үл хөөсөн хүмүүст сайн үйл үйлдэх, шударга хандахыг чинь хориглохгүй. Аллах шударгаар ханддаг хүмүүсийг хайрладаг.”*⁶

Гэгээн элч маш олон хадистээ, шашин нэгт ах дүүсийнхээ эвийг олох нь нэгэн Мусульман хүний үүрэг болохыг, үл ойлголцлуудыг дипломат аргуудаар болон эв нэгдлийн замаар шийдэхийн тулд хичээл зүтгэл гаргах шаардлагатайг, хэлсэндээ хүрэх нь чухал гэдгийг бас сануулдаг. Чухамдаа Аллахын Элч, мүшрикчүүдийн хавчлагаар албадан хүчээр хөөгдсөн Мекке хот руу он удаан жилийн дараа ялалт байгуулсан командлагч болон буцаж ирэхдээ, ялалтын өдрөө цус урсгаагүй, хариугаа аваагүй ба Меккечүүдийг өршөөсөн билээ.

Ислам шашин нь, тайван амгалан амьдрах болон бүх хүн төрөлхтний сайн сайхны төлөөх сайн үйлд нийтээрээ ажиллахын тулд адилхан нэг сүсэг бишрэлтэй байхыг шаарддаггүй. Хамгийн чухал зүйл нь харилцан адилаар энх тайвны хажууд зогсох, хүмүүсийн эрх ба эрх чөлөөнд, итгэл сүсэг бишрэл ба үнэт зүйлд нь

хүндэтгэлтэйгээр хандах юм. Исламын шашин нь олон нийтээрээ амьдрах ёс суртахуун ба амьдралын зарчимд чухал ач холбогдол өгдөг учраас, Исламын соёл нь өөр өөр үндэс угсаатнууд ба өөр сүсэг бишрэлтэй боловч нэг газар хамт бөгөөд тайван аж төрж байсан өвөрмөц жишээнүүд олон бий.

Исламын үндсэн ойлголтуудын нэг болохжихадын тухай энд товч мэдээлэл өгөх нь зүйтэй болов уу. Исламын шашинджихад, Аллахын төлөө зарцуулсан хөдөлмөр, Чин үнэний төлөө зориулсан хүчин чармайлтын нэршил нь юм.жихад, мүмин хүний, амь нас, эд хөрөнгө, бүх зүйлээрээ дэнчин тавин Агуу Рабб эзний талархлыг хүлээх гэсэн зүтгэл чармайлт юм.

жихад, ариун үнэт зүйлсээ хамгаалахын төлөө биемахбодь, хэл яриа, үзэл бодол болон сэтгэлээрээ тууштай байхыг харуулах явдал юм. Мусульман нь, эх орондоо нэр төр, оршин тогтнол ба эрх чөлөөгөөрөө орших; сүсэг бишрэл, туг далбаа, тусгаар тогтнол ба нэр хүндээ хамгаалах гэсэн хичээл зүтгэл юм.жихад гэдэг нь шударга бус нэгэн дайралт, үгүй хийх, цөлмөх колоничлох буюу дарангуйлал огтоос биш юм. Эсрэгээр ньжихад, дарангуйлал ба дарангуйлагчийн эсрэг Мусульманы эрхээ хамгаалах гэсэн оролдлого нь билээ. Мусульман хүн заримдаа гараараа, үзгээрээ, бодол санаагаараа, хэзээ нэгэн өдөр материаллаг бололцоогоороо ба энергиэрээ Аллахын талархлын төлөө хүчээ зарцуулдаг. Зөвийг ойлгуулах, сайн сайханд уриалан дуудах, сайн үйлд шалтгаалан нөлөөлөхийн тулд өдөр

шөнөгүй зүтгэдэг. Сүсэг бишрэл, оршихуй, эх орон, ирээдүй ба эрх чөлөөнийхөө зэвсэгтэй дайнд оролцох нь, жихадын хамгийн сүүлчийн шат юм.

Өнөөдөр Ислам ба жихадын нэр дор терроризмын холбоотонгуудын зүгээс зохион байгуулалттай явуулж буй бохир тоглоомууд нь жихадтай огтхон ч холбоогүй юм. Өршөөл, хүний мөс чанараа алдсан аллагын сүлжээнүүдийн үйлдсэн халдлага ба Мусульманчуудтай холбохыг оролдсон амиа золиолслосон халдлагууд, харгис хэрцгий үйлдлүүд нь жихадын тухай Исламын ойлголттой хэзээ ч нийцдэггүй. Учир нь Исламын шашинд жихад гэдэг нь гартаа буу зэвсэг агсан гэм зэмгүй хүмүүсийн амь насанд халдах биш юм. Исламын шашинд жихад нь хөнөөх бус, амьдруулах, үгүй хийх бус, амилуулах оролдлогын нэршил нь юм. Хэний эсрэг болон ямар ч шалтгаантай үйлдэхээс эс хамааран, гэм зэмгүй хүмүүст чиглэсэн халдлагууд, Исламын жихадтай холбоотой оюун санааны эрч хүч болон үзэл санаатай огтхон ч хамааралгүй юм. Шашин ба сүсэг бишрэлээр, төлөвшил ба хүнлэг чанараар, оюун санаа ба бие сэтгэлтэй огтхон ч нийцдэггүй терроризм, үргэлж хараал хүртэх хувьтай.

Газар дэлхийгээс бүх төрлийн муу муухайг арилгах, үймээн самуун ба эвдэн сүйтгэгсдэд зогс гэх, эв нэгдэл давамгайлан хүн төрөлхтний нийтийн эрх ашиг хангагдах нь хүлээгдэж байгаа билээ. Ислам шашин нь энэхүү нийтийн зүтгэлд урин дууддаг, дарангуйлал ба хэцүү

бэрхийн эсрэг бүгдээрээ хамт зогсохыг болон эв нэгдлийн төлөө гар бие оролцон зүтгэхийг нэн түрүүнд Мусульманчууд болон бүх хүн төрөлхтнөөс хүсэн хүлээдэг. Чухамдаа Исламын элч (с.а.у) Мусульман ба мүмин тодорхойлолт нь маш тодорхой: *“Мусульман гэдэг нь, бусад хүмүүс түүний гар болон хэл ярианаас хохирол учруулаагүй хэн нэгнийг хэлнэ. Мүмин гэдэг нь ард олон, амь нас болон эд хөрөнгийн тухайд өөрт нь итгэл хүлээлгэдэг хэн нэгнийг хэлдэг.”*⁷

7 Тирмизи, Итгэл, 12.

Ислам, Шинжлэх Ухаан Ба Мэргэн Ухааны Шашин



*“(Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Мэддэг,
мэддэггүй хоёр адил гэж үү? хэмээн хэл.””⁸*

(Куран-Карим)

“Бүхнийг мэдэгч” болох, мэдлэгийг бүтээсэн ба бүх зүйлийг мэддэг Аллах эзэн, хүмүүнийг мэдлэг мэдээлэл олж авах болон олж авсан мэдлэгээ ашиглах авьяас чадвараар хангаж өгсөн. Ислам шашин нь, хүнийг төрсний хамтаар ирдэг энэхүү авьяас чадвараа сайн сайханд ашиглах, сурсан болон сургасан зүйл нь хүн төрөлхтөнд үр өгөөжөө хүртээдэг, мэдлэг дор бий болгосноороо эх дэлхийг хамгийн сайн хэлбэрээр бий болгохыг хүсдэг. Чухамдаа Гэгээн элчид анхны айлдвар болон буусан айлдвар “Унш! (Сур)” хэмээсэн.

Ислам шашны “Унш!” айлдвар нь, унших-бичихийг сурахаас гадна бүр илүү гүнзгийгээр орчлон ертөнцийг танин мэдэж унших, ойлгох,

нээн илрүүлэх ба энэ хүрээнд үнэнд хүрэхийг (Бурхан тэнгэрийг танин мэдэх) ойлгуулдаг. Хүмүүн түүний хажуугаар өөрийгөө танин мэдэж унших, оршихуйн шалтгаанаа хайх, гайхамшигтай нэгэн хэлбэрээр бүтээгдсэн бие организмаа болон зүрх сэтгэлээ танин өөрийг нь бүтээсэн Эзэндээ хүрэх хэрэгтэй.

Энэ хүрээнд ядрах, хөдөлмөр болон цаг хугацаагаа зарцуулахад тохирох хамгийн сайн зүйл бол, эрдэм мэдлэгтэй болох явдал юм. Ислам шашин нь, мэдлэгт хүрэхийн төлөө мэдлэг олж авахыг эм-эр хүн бүрд зайлшгүй нэгэн үүрэг хэмээн авч үздэг. Сүүлчийн Элч (с.а.у) энэ талаар ийн айлдсан: *“Сургагч бай эсвэл суралцагч бай, сонсогч бай эсвэл мэдлэгийг хайрладаг ба үнэлдэг бай. Тав дахь нь битгий бай, эс бөгөөс сүйрэн үгүй болно!”*⁹

Үнэн хэрэгтээ элч бүр нэгэн багш сурган хүмүүжүүлэгч ба хүмүүсийг зөв мэдээллийн тусаар энэ ертөнц болон нөгөө ертөнцөд аз жаргалтай болоход урин дууддаг. Учир нь зөв мэдээлэл, Алладын өмнө үнэмлэхүй нэгэн үнэ цэнтэй байдаг. Чухамдаа сүсэг бишрэл итгэлийг ч гэсэн мэдлэг мэдээллээр олж авдаг. Сайн сайхан хүмүүжил төлөвшлөөр мэдлэгт хүрдэг. Эцэст хүн зөвийг мэдсэнээр ба мэддэгээ амьдралд хэрэгжүүлснээр байр суурийг олж авдаг.

Ислам шашны хувьд, хүнийг муу муухай руу хөтөлдөг, буруу ба үндэслэлгүй мэдлэг мэдээллийг шинжлэх ухаан хэмээн нэрлэдэггүй.

9 Дарими, Мукаддима, 26.

Үүнээс гадна мэдлэгээ багахан эд хөрөнгө ашгийн төлөө худалдаж буй хүн, эрдэмтэн мэргэн бус, хөөрхийлөлтэй нэгэн этгээд юм. Учир нь мэдлэг мэдээллийн ч гэсэн нэгэн ёс зүй нь бий.

Гэгээн элч (с.а.у) Аллахаас ашиг тустай мэдлэгийг хүсдэг ба үр шимээ өгдөггүй мэдээллээс Аллахад залбирдаг байсан. Эс өөрчлөгдөх үнэний ба хамгийн зөв мэдлэгийн эх сурвалж нь болох Куран судрыг сурахыг болон сургахыг чухалчлан захисан байдаг. Өөрийнхөө үг болох хадиснуудаа дутуу болон илүүгүй нэгэн хэлбэрээр яг тэр хэвээр нь ирээдүй хойчдоо хүргэсэн хүмүүсийг том шагналууд хүлээж байгааг дуулгасан. Ийнхүү мэдлэг түгээн, мунхаглалыг арилгахыг хүсдэг.

Гэгээн элчийн маш олон хадиснуудад, мэдлэг олж авахын аянд гарсан нэгэн диваажинд орохыг, мэдлэгээ эргэн тойрондоо түгээсэн нэгэн насан эцэс болсны дараа ч гэсэн тэр мэдлэгийг ашиглах болгонд буян хурааж байдгийг, мэдлэгээ нуун хувиа хичээх ба зөвийг мэдэж байгаа мөртөө түүний дагуу үйлдээгүй нэгэн маш том нүгэл үүрдгийг анхааруулсан. Исламын сургаалуудад мэдлэгийг үнэлэх ба мунхаглалаас ангижрах, үүний зэрэгцээ, энэ нь хүмүүсийг Аллахад ойртуулдаг ба буян хишиг арвинтай нэгэн мөргөл залбиралтай адил юм. Тийм ч учраас Гэгээн элч ийн айлдсан: *“Садака өглөгийн хамгийн буянтай нь Мусульман хүний сурсан зүйлээ мусульман ахан дүүстээ зааж сургах явдал юм.”*¹⁰

10 Ибн Мажа, Сунна, 20.

Ислам, Бүх Үйл Хэрэгт Зөөлөн Хандахыг Айлддаг



*“Мүмин хүн бусдын нэр төр, эрх чөлөөнд
халддаг, хараан зүхдэг, муухай зүйлүүд үйлддэг,
ёс суртахуунгүй ярьдаг хүн биш юм.”¹¹*

Гэгээн Мухаммед (с.а.у.)

Үг ба үйлдэлдээ бүдүүлэг байдлаас хол байн, хагалан бутаргах бус, эсрэгээр нь бүтээлч, эвлэг болон эелдэг байх нь, тухайн хүний сайн хүн ба төлөвшсөн нэг Мусульман хүн болохыг харуулдаг. Учир нь Ислам шашин нь, өөрт нь итгэдэг хүмүүсийг төрөл бүрийн бүдүүлэг, муу муухай, эс хүндэтгэл ба хүмүүжилгүй байдлаас хол байхыг уриалдаг. Хараалын үг ба үйлдэл, хар мөртэй бүхнийг, муу муухай үг ба үйлдэл болгоныг Аллахын элчийн зүгээс хориглосон.

Ислам шашны хувьд, хүн бүрийн биемахбодь, амь нас, оюун санаа ба нэр хүнд нь бүх төрлийн шударга бус хөндлөнгийн оролцоо, заналхийлэл, доромжлолоос хамгаалагдсан.

11 Тирмизи, Бирр ба Сыла, 48

Үүний адилаар, хүний эд хөрөнгө, ээж-аав, гэр бүлийн гишүүд, тэдний харьяалагддаг үндэс угсаа, үндэстэн болон сүсэг бишрэлийн систем нь ч гэсэн үйл хэрэг болон аман халдлагын бай болох ёсгүй. Үзэл бодлын зөрүүнд хүндэтгэлтэй хандан; үзэл санааны зөрүүгээ хүчээр бус ярилцах; асуудлыг шийдэж байх явцдаа хууль болон ёс суртахууны эсрэг алхмууд хийж болохгүй. Мөн, гэм буруутан ч гэсэн шийтгэлээ хүлээдэг гэхдээ түүнийг доромжлох болон эрүүдэн тамлаж болохгүй.

Нөгөөтээгүүр, Мусульман хүн зөөлөн сэтгэлтэй, бусдыг ойлгох болон зөөлөн хандлагаа, зөвхөн хүмүүст бус үүний зэрэгцээ ан амьтан болон ургамалд ч гэсэн адилхан зөөлөн хандах ёстой. Байгаль орчинтойгоо нөхөрлөх ба бусад биет оршихуйд ч гэсэн энэрэнгүй, өр зөөлөн ба шударга ёсны хэмжүүрээр хандах нь шашны үүрэг айлдвар юм.

Сүүлчийн Гэгээн элч (с.а.у) Мусульманчуудад бүхий л үйл хэрэгтээ “ихсан” буюу хольцгүй болон ямар нэгэн хүлээлтгүй нэгэн тусын хүрээнд хандахыг зөвлөсөн. Түүний үлгэр жишээ амьдрал, нэн түрүүнд гэр бүлдээ болон бүх хамаатан садандаа, найз нөхдөдөө, бүр өөрийнх нь шашнаас өөр шашинтай хүмүүст ч гэсэн ёс зүйтэй болон зөөлөн хандаж байсан жишээнүүдээр дүүрэн.

Ислам, Хайр Энэрлийн Шашин



*“Би хараалч бус, зөвхөн хайр
энэрлээр илгээгдсэн.”¹²*

(Гэгээн Мухаммед^(с.а.у))

“Рахман” ба “Рахийм” болох Аллах, хязгааргүй энэрлээрээ бүхий оршихуйг нигүүлсэн, хамгаалдаг ба буян хишгээрээ хангаж өгдөг. “Миний хайр энэрэл уур хилэн шийтгэлийг маань давсан.”¹³ хэмээсэн ба энэхүү хайр энэрлээрээ хүмүүсийг өршөөдөг. Хүмүүсийг ч гэсэн энэрэнгүй байх болон зөөлөн хандахыг шаарддаг.

Хүн төрөлхтний хамгийн төгс гишүүн болох Гэгээн элч (с.а.у.) хайр энэрлийн элч юм. Хайр энэрэл болон нинжин сэтгэлийн элч юм. Хатуу сэтгэлтэй ба бүдүүлэг биш учир нөхөд түүнийг тойрон хүрээлж, хүчээр шийдэх дуртай харанхуй нийгмийг, түүний удирдлага дор хайр энэрэлтэй танилцсан.

12 Муслим, Бирр Ба Сыла, 87.

13 Бухари, Таухид, 22.

Гэгээн элчийн сүннетэд хайр энэрэл, харуусах төдий сэтгэл хөдлөл бус, “оршихуйг хүндэл” гэсэн чухал байр суурь юм. Учир нь Ислам шашны хувьд, Алладын зүгээс бүтээгдсэн том-жижиг бүхий л оршихуй бүтээл нэгэн өөрийн гэсэн үнэ цэнийг агуулдаг ба хайр энэрлийг хүртэх ёстой. Газар Газар дэлхийд буй бүхэн хайр энэрэл үзүүлсэн хүн төрөлхтөн түүнийхээ хариуг Алладын хайр энэрэл болгон хүртдэг.

Мэдээж хайр энэрлийн хамгийн сайн тусгал нь, Мусульманчуудын хоорондох харилцан хайр, энэрэл, буян хишиг ба туслах сэтгэл юм. Гэвч хайр энэрэл нь зөвхөн хүмүүст, мусульманчуудад, сайн нэгэнд болон ядууст үзүүлсэн харилцааны нэр нь биш юм. Ялангуяа хүүхэд, өндөр настан ба өвчтэй гэх мэт өөрсдийн эрх ашгийг хамгаалж чадахгүй ба хүмүүст хариуцуулж өгсөн амьтадын өмнө ч гэсэн энэрэнгүй хандах нь Исламын ёс суртахууны шаардлага юм.

Хайр энэрлийн эсрэг утгыг илтгэх дарангуйлал ба албадлага бол Исламд маш тодорхой хэлээр хориглосон байдаг. Хүний оюуны болон биеийн хүчээ муу муухайд ашиглан бусармаг үйлдэл гаргах нь, нэн түрүүнд «газар дэлхийг тайван амгалангийн төлөө бүтээсэн» үнэнтэй тэрсэлдэх юм. Албадлага хүчирхийлэл, хэнд болон хэний эсрэг байсан ч гэсэн хүлээн зөвшөөрч болохгүй. Физиологийн, сэтгэл санааны эсвэл эдийн засгийн бүх төрлийн албадлага нь, халдашгүй эрхийг зөрчдөг тул хүний эрхийг зөрчсөн хэрэг болдог.

Энэ талаар Алладын элчийн сүннет буюу амьдралын хэлбэр нь жинхэнэ утгаараа албадлага хүчирхийллийг зогс гэсэн ба хайр энэрлийг зарчим болгосон нэгэн ойлголтод эзэн. Алладын элч (с.а.у.) харанхуй үеийн албадлага хүчирхийллийг агуулсан бүхий л сөрөг сүсэг бишрэл ба үйлдлээс татгалзсан. Атгаг санаа, уур хилэн, атаархал, шунал, өс хонзон, сэтгэлийн шарх ба нус нулимсыг авчирдаг албадлага хүчирхийллийг, нийгмийн хамгийн үнэ цэнтэй суурь болох гэр бүлээс эхлээд бүхий л давхаргад арилгахын төлөө зүтгэл гаргасан. Хүүхэд эмэгтэйчүүдийн талаарх хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтыг огтхон ч хүлээн зөвшөөрөлгүй тэдний эрхийг болон нэр хүндийг хамгаалсан. Гэр бүлийн дотор болон нийгмийн амьдралын хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг ширүүн, догшин, хэрцгий ба хайр энэрэлгүй нэгэн хандлага үзүүлэх нь, Исламын үндсэн эх сурвалжуудаас баталгаа олох боломжгүй зүйл.

Нөгөөтээгүүр, Гэгээн элчийн дайн дажин гэх мэт албадлага хүчирхийлэл оргилдоо хүрдэг нэгэн орчинд хууль эрх болон ёс суртахууныг сахихыг айлдсан нь, олзлогсдод сайн хандахыг хүсэх нь, өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүд ба шашны хүмүүсийг дайн тулаанд алахыг хориглосон нь онцгой ач холбогдолтой. Дайны талбарт ч гэсэн хүчирхийлэл болон харгис хэрцгийг хүлээн зөвшөөрдөггүй нэгэн шашны гишүүд болох Мусульманчууд, хайр энэрлийн элч нар нь билээ. Учир нь зүрхэнд нь сүсэг бишрэл ба хүнийг хайрлах сэтгэл, зүрх сэтгэлд нь хувь хүний эрх ашиг болон нөгөө ертөнцийн

ухамсар, өмнө нь Куран судар болон Гэгээн элчийн жишээ нь байдаг.

Тусламж хэрэгтэй байгаа нэгэндээ туслах, хэцүү байдалд буй нэгнээ хамгаалах ба аврах, амьдарч буй орчиндоо хайр энэрэл ба итгэлээр таниулах мумин буюу сүсэг бишрэлтэй хүний үүрэг нь юм. Учир нь мумин, хайр энэрлээр дүүрэн нэгэн шийдвэрээр, хайр энэрлээр тэтгэгдсэн нэг өгүүлбэр эсвэл хайр энэрэлд сунгасан гарынхаа ач тусаар хайр энэрлийн жинхэнэ эзэн Аллахад ойртдог. Гэгээн элчийн өгүүлснээр *«Хүмүүст хайр энэрэл үзүүлээгүй нэгэнд Аллах эзэн ч гэсэн хайр энэрэл өршөөлөө үзүүлдэггүй»*.¹⁴

14 Бухари, Таухид, 2.

Мусульман, Хариуцлагын Ухамсрыг Эрхэмлэдэг



*"Хүн өөрийгөө хараа хяналтгүй
орхигдоно гэж боддог уу?"¹⁵
(Куран-Карим)*

Агуу Аллах, бусад амьтдаас ялгаатай болох “оюун ухаан” ба “сонголт хийх эрх” өгөх хэлбэрээр хүмүүнийг онцгой болгосон. Түүнийг төрөл бүрийн авьяас чадвараар ханган, гаргасан шийдвэрүүдээ хэрэгжүүлэх эрхийг өгсөн. Сонголт шийдвэрээ шударга үнэний талд, зөв зүйтэйд, сайн сайханд ашиглах, эрх чөлөөнийхөө хэмжээг хариуцлага ухамсрын хүрээнд ашиглахыг хүсдэг. Эцэст нь хорвоо дэлхийн амьдрал нь нэгэн шалгуур ба хариуцлагагүй үйлдэл эсвэл тодорхойгүй шийдвэрүүд нь шалгуурын язгууртай нь зөрчилддөг.

15 Кияме, 75/36

Хариуцлага, хүний амьдралыг чиглүүлдэг, түүнийг зорилгогүй амьдрахаас авардаг. Хариуцлагын эзэн болсон хүн, амьдралдаа зөвхөн боломж буян хишгүүд бус, үүргүүдээ ч гэсэн ухамсарладаг. Эрхүүдийнхээ адилаар хариуцлагадаа ч эзэн байдаг. Хариуцлагаа биелүүлснээр аз жаргалтай ба тайван амгалан болдог.

Куран сударт тодорхой өгүүлснээр, Аллах эзэн оюун ухаан ба сонголтын эзэн албатууддаа үүрүүлсэн хариуцлагууд зөвхөн тэдний үүрч чадахуйц хэмжээнд л хариуцлага үүрдэг. Албатуудаа хамгийн сайн таних ба тэдний төлөө үргэлж сайн сайхныг хүсдэг Аллах, мартах буюу санамсаргүйгээр алдаа гарган үйлдсэн нүглүүдээс болж албатууддаа хариуцлага үүрүүлдэггүй. Бүр зүрх сэтгэл дотроо бодсон муухай бодлуудыг үйлдэл болгоогүй тохиолдолд түүнийг өршөөдөг.

Аллахын өмнө хариуцлагаа ухамсарлан амьдрах нь, өөрийгөө Аллахаас заяагдан ирсэн, Түүний эзэмшлийнх гэдгээ мөн эцэс сүүлд нь Түүн рүү эргэн очно гэдгээ ухамсарлах нь зүйтэй. Бүх зүйлийг харж буй, сонсож буй ба мэдэж буй Аллахын үргэлж өөртэй нь хамт болохыг санаанаасаа гаргахгүй байх хэрэгтэй. Энэ ухамсрын дагуу амьдралаа чиглүүлэн, гишгэж буй алхам бүртээ энэхүү ухамсраар алхах хэрэгтэй.

Хүний Аллахын өмнөх үндсэн хариуцлага нь, Түүний оршихуйд ба цор ганц гэдэгт итгэн сүсэглэх, ямар ч зүйлийг түүнтэй адилтгахгүй

байх, албатын хувиар үүргээ биелүүлэх юм. Гэхдээ Аллахтай болох бидний харилцаа, хүмүүстэй харилцах харилцаанд ч гэсэн нөлөөлдөг. Тийм учраас Аллахын бидэн дэх эрх үүргүүд нь, зөвхөн мөргөл залбирал бус, бүхий л хүмүүсийн эрх ашгийг хамарсан нийгмийн сэдвүүд ч багтдаг. Учир нь хүн өөртөө, гэр бүлдээ, төрөл төрөгсдөдөө, нийгэмдээ болон байгаль орчны өмнө хүлээсэн үүргүүд нь бий.

Ислам шашин нь, эрх ба хариуцлагыг нэг жинлүүрийн хоёр туухай адил үздэг. Хүмүүсийн хоорондоо хүлээсэн эрх үүргүүд, жам ёсоороо тэдний харилцан хариуцлагыг бий болгодог. Эрх үүргээ эдлэхийг хүссэн хүн, хариуцлагаа хүлээх ёстой. Иймэрхүү нэгэн тэнцвэрт байдал тогтоосноор, амар амгалан хувь хүмүүс болон хүчирхэг нэгэн нийгмийг бий болгох боломжтой болно.

Мусульман, Гэр Бүлдээ Сайн Сайхнаар Ханддаг



*“Та нарын хамгийн сайн нь, гэр бүлдээ
сайнаар хандсан нь. Би ч гэсэн гэр
бүлдээ хамгийн сайнаар ханддаг.”¹⁶*

Гэгээн Мухаммед (с.а.у.)

Гэр бүл болох ба эрүүл хойч үеийг өсгөх нь Ислам шашны зүгээс үргэлж зөвлөдөг нэгэн амьдралын хэлбэр юм. Куран сударт эмэгтэй ба эрэгтэйн хорон дахь хайр энэрлийн холбоо нь Аллахын оршихуйн нотолгоо ба гэр бүл нь Түүний нэгэн буян хишиг нь хэмээн өгүүлэгддэг. Гэрлэх нь зөвхөн тусгай нэгэн хэсэг бүлэгт зориулагдсан бус, материаллаг эд хөрөнгийн хүрэлцээгүй газарт шинээр нэгэн гэр бүл бий болохын тулд тусалж дэмжих хэрэгтэй хэмээн чиглүүлдэг. Зөвхөн, адил төсгүй ба хамтрагч нь үгүй, хэн нэгний тусламж шаардлагагүй ба бүх зүйл Түүнд хамааралтай болох цор ганц

16 Тирмизи, Менакиб, 63.

оршихуй Аллаха эзэн юм. Тийм учраас хүний хувьд хань ижилтэй болох ба гэр бүл зохиох нь жам ёсны хэрэгцээ юм.

Ислам шашин нь, гэр бүл болохын адилаар, нэгэн гэр бүл байхын хариуцлага үүрэхийг шаарддаг. Гэр бүл болох нь, нэгэн мэдрэмж ба сэтгэл санааны нэгдэл, нөхөрлөл, итгэлцэл, энэрэл, шударга ёс, сайн сайхны төлөө хамтдаа нэг нэгэндээ туслах болон муу муухайгүйн эсрэг хамтын тэмцэхийг шаарддаг.

Ислам шашны хувьд, гэр бүл дотор хүчирхийллийг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй. Бүхий л сэдэвт байдгийн адилаар гэр бүлийн амьдралд ч гэсэн бидний хувьд хамгийн сайн үлгэр жишээ болох Аллахын Элч (с.а.у) эхнэрүүддээ, хүүхдүүддээ болон тэнд хажууд нь үйлчилж байсан хүмүүст нэг ч муу үг хэлээгүй, хань нь ¹⁷Тэгээн Айшагийн өгүүлснээр “Амьдралынхаа турш нэг удаа ч гэсэн нударга зөрүүлж байгаагүй.” Учир нь хүний хань ижилдээ, хүүхдүүддээ, эцэг эхдээ, ах дүү эсвэл төрөл саднаа чиглэсэн бүхий л түрэмгий үйлдэл нь хуулийн өмнө гэмт хэрэг, Аллахын өмнө нүгэл юм.

Мусульман хүн хань ижил, үр хүүхэд, эцэг эхтэйгээ нэгэн гэрт амьдрах нь агуу том буян хишиг гэдгийг тэр мэддэг. Гэвч бүхий буян хишгийн адилаар гэр бүл ч гэсэн үүний зэрэгцээ нэгэн сорилт шалгуур гэдгийг ухамсарлах зүйтэй. Иймээс гэр бүлийн харилцаа холбоог бэхжүүлэх ба гэр бүлээ бүх төрлийн муу

17 Муслим, Федаил, 79.

муухайгаас ба аюулаас хамгаалах, эмэгтэй болон эрэгтэй Мусульман хүний үүрэг хариуцлага юм. Гэр бүлийн гишүүдийн хооронд ялгаварлан гадуурхалгүйгээр шударга хандах, бүхий л гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах, хайр хүндлэлээр харилцаа тогтоох нь Мусульман байхын шаардлага юм.

Мусульман, Орчиндоо Ээлтэй



*“Та нарын хэн нэгний гарт модны
суулгац байх аваас, дэлхий сөнөж
байсан ч түүнийгээ таригтун.”¹⁸*

(Тэгээн Мухаммед^(с.а.у))

Аллах эзэн, газар дэлхийд амьдралаа эхлүүлсэн өдрөөс өнөөдрийг хүртэл хүмүүнд орчлон ертөнцийг таниулан, энэ ертөнцийн утга учрын тайллыг түүнд ойлгуулсан ба байгаль эх дэлхийтэй хэрхэн харилцах талаар түүнийг сургасан. Чухамдаа сүүлчийн ариун судар болох Куран-Каримд ертөнц дэлхийн ажиллагааг, оршихуйн хорон дахь тэнцвэрт байдал ба дэг журам, бус бүрийн бүтээгдсэн зорилгыг болон Агуу Бүтээгч Эзэн бий мөн түүний хүч чадал, түүний мэргэн ухааны нотолгоонууд болохыг харуулсан маш олон тооны айлдварууд бий.

Хамгийн жижгээс хамгийн том нь хүртэлх ертөнц дахь бүхий л оршихуйнхтайд,

18 Ибн Ханбел, III, 184.

физиологийн үнэ цэний хажуугаар оюун санааны нэгэн үнэ цэнэ нь байдаг. Учир нь тэнгэр ба газарт юу байгаа тэд бүгд Аллахыг магтан дуулдаг. Шувуудаас эхлэн хад чулуу, ургамлаас хорхой шавж, Нарнаас од хүртэлх амьгүй, сэтгэл хөдлөлгүй ба зорилгогүй ямар ч оршихуй үгүй билээ. Ислам шашны хүрээлэн буй орчиндоо ач холбогдол, нэн түрүүнд бүхий л оршихуйн бүтээгдсэн зорилго мөн чанараараа үнэ цэнтэй байх зарчим дээр тулгуурладаг.

Ислам шашны бодлогын тогтолцооны дагуу, хүрээлэн буй орчин, Аллахын зүгээс бүтээгдсэн, цаг мөч бүрд Түүний зүгээс хянан ба удирддаг мөн хүнд даатган хүлээлгэж өгсөн. Учир нь хүн, амьд оршихуй дотроос орчноо хамгийн дээд түвшинд мэдэрдэг, хэлбэржүүлдэг, ашиглаж чаддаг ба Бүтээсэн Эзэнтэйгээ холбоо тогтоож чаддаг оршихуй юм. Энэхүү шалтгаанаар Аллах, байгаль орчныг, тэнгэр болон газарт байгаа бүх зүйлийг хүний хэрэгцээнд зориулж өгсөн. Гэхдээ энэхүү үйл явц нь, хүн төрөлхтний орчлон ертөнцөд хязгааргүйгээр эзэн суух гэсэн утгыг илтгэдэггүй. Хүн төрөлхтөн энэ ертөнц дэлхийн эзэн ноён нь бус, хамгаалагч нь юм. Хүссэнээ үйлдэн орчиндоо хохирол учруулах, хүч болон эрх ашиг олж авахын төлөө орчноо үгүй хийсэн тохиолдолд Аллахын өмнө хариуцлагаа хүлээдэг.

Аллах эзэн, газар дэлхийг зөвхөн хүн төрөлхтөнд бус, ан амьтан ба ургамлын амьдрах орчин болгон бүтээсэн. Тийм учраас Мусульман хүн, амьтан ба ургамлын амьдрах эрхийг нь хамгаалж, тэдэнд хүнлэг, хайр энэрлээр ханддаг.

Гэгээн Элч, шалтгаангүйгээр алагдсан нэгэн бор шувуу ч гэсэн их шүүлтийн өдөр Аллахад өөрийн байдлыг өргөн барьж гомдоллох болно гэдгийг сануулан хэлдэг.¹⁹ Тиймээс Исламын шашны байгаль орчны ёс суртахуун нь хувиа хичээх, материаллаг үзэл, Шунал ба харанга байдлаас хол байх байр суурийг илэрхийлдэг.

Хорвоо ертөнц, бүх гоёмсог байдлаараа Агуу Бүтээгч эзний хүн төрөлхтөнд өгсөн бэлэг нь юм. Хүн төрөлхтөн өөрийн гараар оролцон хордуулалгүй, тайрах ба галдан үгүй хийгээгүй тохиолдолд, байгаль дэлхий өөрийн тогтолцон дотроо цэвэрхэн үлддэг. Мусульман хүн байгаль орчны талаар хариуцлага хүлээдэг, байгалийн онгон байдлыг хамгаалдаг ба түүнтэй зохицон амьдардаг. Чухамдаа байгаль орчин нь хүний хамгийн чухал үнэт эрдэнэ ба ирээдүй нь юм.

19 Несай, Дахаяа, 42.

Мусульман, Хэзээ ч Дарамталдаггүй



*“Агуу Аллах ийн айлдсан: Би дарамт шахалтыг
өөртөө ба албатууддаа харам болгосон. Тиймээс
та нар ч гэсэн нэг нэгнээ бүү дарамтлагтун.”²⁰*

(Тэгээн Мухаммед^(с.а.з))

Дарангуйл; жинхэнэ эзэнд оногдох хувийг нь эс өгөх, нэгэн өглөгийг зохисгүй газар хэрэглэхийг хэлнэ. Дарангуйлал нь бүх төрлийн хавчилт, зүй бус байдал, хүнлэг бус, шударга бусын нэгдмэл нэршил юм.

Ислам шашны хувьд, хамгийн том дарангуйлал, Аллахын эрх ашгийг Аллахаас бусдад шилжүүлэх буюу Аллахаас өөр бурхан тэнгэр бий болохыг хүлээн зөвшөөрөх явдал юм. Хүн төрөлхтнийг бий болгосон ба хэмжээлшгүй буян хишгээр хангаж өгсөн ч Аллахыг өөр нэгэн оршихуйтай адилтган үзэх нь, ширк (Аллахыг өөр нэг оршихуйтай зүйрлэх) юм. Ширк (Аллахыг өөр нэг оршихуйтай зүйрлэх)

20 Мүслим, Бирр ба Сыла, 55.

Аллахаас гадна өөр бурхан тэнгэрийг бий болгох, олон бурхантай сүсэг бишрэлийн системийг хөгжүүлэн дараа нь түүндээ мөргөн залбирахыг хэлнэ. Энэ нь жинхэнэ утгаараа нэгэн дарангуйлал юм.

Ширк үйлдэхийн зэрэгцээ, Аллахын айлдваруудыг үгүйсгэх, Куран Судар ба түүний шийдвэрүүдийг эс хүлээн зөвшөөрөх, Аллахын элч ба элч нарт үл итгэх нь дарангуйлал юм. Хүн төрөлхтөн иймэрхүү байдалд орсноор Рабб эзнийхээ эсрэг дарангуйлагсдын дотор газар авах ёсгүй. Итгэл сүсэг бишрэлээс гадуур үлдэн өөрийгөө дарангуйлалд автуулах шаардлагагүй. Рабб эзэнтэйгээ ойрхон нэгэн холбоо тогтоосноор түүний өгөх аз жаргал, тайван амгалан ба аюулгүй амьдрах ёстой ба энэ ертөнц болон хойд ертөнцийг өөртөө гяндан болгох шаардлагагүй.

Үүний зэрэгцээ хүн, орчинтойгоо бусад хүмүүстэй, амьд амьгүй бүхий л оршихуйг хэзээ ч дарангуйлах ёсгүй. Хүмүүсийн хооронд харилцаандаа хатуурхан дарлах, нөгөө талынхаа хил хязгаарыг үл харгалзах, эрхийг нь булаан авах, түүнд эс шударга болон энэрэлгүй хандахыг хэлнэ.

Ислам шашинд дарангуйллыг хориглохдоо Мусульман болон Мусульман биш ялгаа гаргадаггүй. Учир нь дарангуйллын эсрэг зогсоогүй тохиолдолд нийгэмд шударга бус байдал газар авдаг, хүчтэй бөгөөд дарангуйлагч нэгэн нийгмийн амгалан тайван байдлыг алдагдуулах зүй ёсных болдог. Тиймээс

Мусульман хүн, ямар ч тохиолдол байсан ч хамаагүй, дарангуйлагчийн эсрэг, дарлалд өртөж буй нэгний хажууд зогсдог. Үнэнийг ба шударга ёсыг хамгаалдаг, хууль шударга ёсноос огтхон ч нүүр өгдөггүй.

Ислам шашин нь, хүний Рабб эзэндээ ширк үйлдэхийн хажуугаар дарангуйллын бүх төрлийг хориглосон ба дарангуйлагсад Алладын зүгээс эс таалагдана, хэзээ ч дэмжигддэггүй ба аврагдаж чадахгүй гэдгийг маш тодорхой нэгэн хэлбэрээр өгүүлсэн байдаг.

Мусульман, Шударга ба Үнэн Үгтэй



*“Аллахад итгэдэг хэмээн хэл, дараа
нь шударга үнэнч бай!”²¹
(Гэгээн Мухаммед^(с.а.у))*

Шударга үнэн, үгний мөн чанар үгтэйгээ нэгдэх, хүний хүсэл ба үг үйлдлүүд нь нэгэнтэйгээ нийцэхийг илтгэсэн нэгэн ёс суртахууны зарчим юм. Мэдээжийн хэрэг Исламын ёс суртахууны зарчимд ч гэсэн үнэн үгтэй, итгэл даах ба шударга байхын маш чухал нэгэн орон зай байдаг.

Бидний гэгээн элч маань, иман (сүсэг бишрэл) шударга ёс хоёрын хооронд онцгой ач холбогдол өгдөг. *“Биднийг хууран мэхэлсэн биднээс биш!”²²* хэмээн Мусульман хүний зан чанарт худал, хуурмаг, хоёр нүүр гаргахыг хэзээ ч зөвшөөрдөггүй. Түүний хэлснээр “Аллахад болон хойд ертөнцөд итгэн сүсэглэдэг хүн сайн үг хэлэх эсвэл чимээгүй байх хэрэгтэй.”²³

21 Муслим, Иман, 62.

22 Муслим, Иман, 164.

23 Бухари, Рикак, 23

Мусульман хүн хамгийн эхэнд Рабб эзэндээ үнэнч байх ёстой. Түүнийг хүлээн зөвшөөрч, Түүнтэй чин сэтгэлээсээ холбогдох хэрэгтэй. Дараа нь хүсэл тэмүүлэл ба зан үйлдээ тууштай замыг дагах ёстой; үнэнч шударга байдлаараа хүрээлэн буй орчиндоо итгэлийг бий болгох ёстой. Мөн гэр бүлдээ, бизнесийн хүрээнд, ажил төрөлдөө, бүр баярлан цэнгэхдээ хүртэл худал хэлэхээс зайлсхийх шударга үнэнийг зарчмаа болгон, тухайн хамгийн ойроосоо эхлэн хүрээлэл үүсгэснээр хүчирхэгжиж буй нэгэн нийгмийг бүтээдэг.

Мусульман, Талархлаа Илэрхийлдэг Албат



“Үнэндээ Бид та нарыг дэлхийд байршуулсан.

*Та нарын төлөө амьдрахын боломжоор
хангасан. Аллахын ивээлд талархаж
залбирах чинь тун бага байна шүү дээ!”²⁴*

(Куран-Карим)

Исламын шашинд, буян хишгийн үнэ цэнийг ойлгох ба хүртээсэн буян хишгээс хамааран Аллах эзэндээ талархлаа илэрхийлэхийг “шүкүр” хэмээн нэрлэдэг. Шүкүр буюу талархал нь, заримдаа зүрх сэтгэл дотроо заримдаа үг яриагаараа илэрхийлснээр Аллахад талархан, Түүний буян хишгүүд дор нэгэн амьдралаа үргэлжлүүлж буйгаа хүндэтгэлтэйгээр илэрхийлэхийг хэлнэ.

Зүрх сэтгэлийн талархал нь, буян хишгээ хайрласан нь Аллах гэдэгт сүсэглэн итгэх юм. Хэл ярианы талархал нь, энэхүү боломжууд болоод буян хишгүүдийн төлөө чин сэтгэлээсээ

24 Араф, 7/10.

талархахыг хэлдэг. Биемахбодийн талархал нь, энерги хүчээ Аллахын талархлын төлөө зөв үйлст зарцуулах, намаз мөргөл ба мацаг гэх мэт мөргөл залбирлуудыг гүйцэтгэх болон Аллахын хорьсон зүйлүүдээс хол байх юм. Эд хөрөнгийн эзэн байхын талархал нь, садака ба зекат өглөг өгснөөр шаардлагатай хүмүүсийг харж хандах; албан тушаал ба нэр хүндийн эзэн байх аваас хүчээ сайн сайханд ба шударга ёсны төлөө ашиглахыг хэлнэ.

Талархал нь, өөрөөр хэлбэл нэгэн албатын ухамсар, нэгэн амьдралын хэв маяг юм. Ууж идэхээс өмсөж зүүх хүртлээ, биемахбодь ба оюун санаа авьяас чадвар материаллаг болон зүрх сэтгэлийн боломжууд хүртэл тоолж баршгүй маш олон буян хишгүүдийн өмнө аз жаргалаар дүүрэн нэгэн албатын Рабб эзнээ мартахгүй байх явдал юм.

Хүний талархлаа илэрхийлэх хэрэгцээ нь угаасаа байдаг. Хүн, өөрт нь өчүүхэн төдий сайн зүйл хийсэн нэгэнд сэтгэлээсээ талархахыг өртэй мэт мэддэг учир, энэхүү буян хишгүүдийг хайрласан Рабб эзэндээ талархлаа үл ойшоож болохгүй. Өөрийнхөө сул дорой гэдгээ ухамсарлан; Аллахын тусламж, туслалцаа болон буян хишиг нь эс байваас амьдарч чадахгүйгээ ойлгох хэрэгтэй.

Нөгөө талаас, Исламын ес суртахууны үүднээс, Аллахад талархах талархлыг төгс болгодог нэг хэсэг нь өөрт нь сайн зүйл үйлдсэн хүмүүст талархах юм. Гэгээн элч с.а.у “Хүмүүст талархлаа эс илэрхийлэх нь, Аллахад

эс талархсан болно."²⁵ хэмээн айлдсан. Талархал нь, хүмүүсийн хооронд хайр энэрэл, харилцаа ба дотно харилцааг үүсгэн тус мэдэхгүй ба хувиа хичээх зэрэг муу зуршлуудыг үгүй хийдэг. Өөрт нь сайн хандсан, дайлж цайлсан, тусалсан нэгэн хүнд ижил хэлбэрээр харилцах, хэрэв өөрт нь үүнийг хийх санхүүгийн боломж байхгүй бол дуа залбирал үйлдэх нь Мусульман хүний ёс суртахууны шаардлага нь юм.

25 Тирмизи, Бирр ба Сила, 35.

Мусульман, Алдаа Гаргахдаа Уучлал Хүсдэг



*“Хэн (хулгай хийж) гэмт хэрэг үйлдсэний
нүглээ наманчлан засарвал Аллах түүний
гэмшилийг хүлээн авна. Аллах нэн өршөөгч
бөгөөд машид нигүүлсэгч билээ.”²⁶*

(Куран-Карим)

Агуу Аллах, хүмүүнийг сайн сайхан ба зөв рүү тэмүүлэлтэй нэгэн байдлаар бүтээсэн, түүнд оюун ухаан, бодол санаа, сонголт хийх чадвар ба сэтгэл зүрх гэх мэт потенциалын хүчийг бий болгон өгсөн. Энэхүү боломж потенциалыг зөв ашиглан сайн сайхан руу чиглэсэн хүн, Аллахын талархлыг хүлээн өөртөө болон хүмүүсийн төлөө сайн сайхныг бүтээдэг. Харин өөрийнхөө, буг чөтгөр ба муу найзуудын уруу таталтаар дамжуулан өөрийн боломжоо бузар муугийн төлөө ашиглавал өөрийгөө болон эргэн тойрныхоо хүмүүсийг өрөвдөлтэй байдалд оруулах болно.

26 Майда, 5/39.

Хүн төөрөлдөж болно. Хүн төрөлхтөн заримдаа хууртагдан, эндүүрч, мартаж, өөрийгөө хянаж чадалгүй, алдаа гаргадаг. Нүгэл үйлдсэн Мусульман хүний төлөө нэгэн гарц, нэгэн буцаах боломж ба нүглээ наманчлах шаардлагатай. Тиймээс Агуу Аллахын албатууддаа олгосон энэхүү өршөөлийн гарц нь, таубе буюу наманчлал юм.

Ислам шашны хувьд, үйлдсэн нүглээсээ улбаатайгаар гэмшин харамсаж Аллахаас өршөөл эрэхийг «истигфар», дахин адилхан алдаагаа давтахгүй гэсэн шийдвэрийг наманчлал гэж нэрлэдэг. Аллахын бас нэг нэршил нь «ат-Таууаб» буюу наманчлал өршөөлийг маш ихээр хүлээж авдаг. Тэр маш энэрэнгүй, албатынхаа гэмшилд ач холбогдол өгдөг, өршөөл уучлал үзүүлэх дуртай ба наманчлал үйлдэн тухайн байдлаа зөвөөр эргүүлснийг өршөөдөг.

Чин сэтгэлээсээ үйлдсэн наманчлал, нэгэн мөргөл залбирал мөн шинэчлэгдэх болон ариусах боломж юм. Төлөвших нь, өөрийгөө хариуцлага тооцох замаар алдаанаас зайлсхийх, итгэл ба найдвараар шинээр дахин эхлэх арга юм. Агуу Аллахын хязгааруудыг эвдэн давж үйлдсэн буруу үйлдлүүдийг цэгцлэх нь, Түүний хайр болон анхаарлыг татах арга юм.

Наманчлал нь, ухамсартай ба шийдэмгий үйлдэл юм. Мусульман хүн наманчлалынхаа ачаар өөртөө итгэх ба өөрийгөө гэсэн хүндлэлийг бэхжүүлж өгдөг. Нүглээс татгалзан орчин тойрондоо сайн сайхны жишээ нь болдог.

Гэгээн элч маань нэгэн хадистээ өгүүлснээр,
*«Нүглээ наманчлан өршөөл эрсэн нэгэн, огт нүгэл
 үйлдээгүй мэт болдог.»*²⁷

Мусульман хүний хувьд хувь хүний эрх ашиг ба нийтийн эрх ашгаас гадна, харамсаж гэмшин наманчлал үйлдвэл Аллах эзний өршөөхгүй нэгэн нүгэл байхгүй. Хувь хүний эрхийг зөрчсөн хүмүүстэйгээ уучлал эрэн, хохирлыг нь барагдуулснаар, нийтийн эрх ашгийн хувьд хуулийн өмнө хариуцлага хүлээх замаар төлдөг.

27 Ибн Мажа, Зухд, 30.

Мусульман, Диваажинд Хүрэх Замыг Эрэлхийлдэг



*“Хэн, Рабб хэмээн Аллахыг, шашин хэмээн
Исламыг болон Элч хэмээн Мухаммедыг
хүлээн зөвшөөрч байна. Хэмээвээс
заавал диваажинд орох болно.”²⁸
(Гэгээн Мухаммед^(с.а.у))*

Анхны хүн болох Гэгээн Адам ба гэргий, диваажингаас газар дэлхий дээр буусан. Энэ ертөнцийн амьдрал нь чухамдаа хүн төрөлхтний хувьд түр зуурын нэгэн аялал ба харь нутаг юм. Энэхүү шалтгаанаар хүн бүр диваажинг санан дурсдаг, диваажин мэт нэгэн амьдралыг хүсдэг, бүхий л газарт диваажинг эрдэг. Чухамдаа Ислам, хүмүүний зүрх сэтгэлд байр суурийг эзэлдэг диваажингийн хүслийг биелүүлэх арга замуудыг түүнд сургадаг.

Мусульман хүнийг диваажинд хүргэх замын эхэнд мэдээж иман буюу сүсэг бишрэл байдаг. Диваажингийн буян хишгүүдэд зөвхөн Аллахад,

Түүний Элч Мухаммед Мустафад болон Түүний агуу шашин Исламд сүсэглэн итгэснээр хүрэх боломжтой.

Сүсэг бишрэлд буяны сайн үйлүүд болон мөргөл залбирлууд ба сайн үйлдлүүд хамтаар байх хэрэгтэй. Тиймээс Мусульман хүн, намаз мөргөлөө хэзээ ч орхигдуулдаггүй. Мацгаа барьдаг. Эд хөрөнгөнийхөө зекет өглөгийг өгдөг. Хаж мөргөлөө үйлдэн, Рабб эзнийхээ гэр нь болох Кабед зочлон очдог. Энэхүү үндсэн мөргөл залбирлуудаас гадна Аллахын талархлыг хүлээх төрөл бүрийн үг яриа, хичээл зүтгэл, хүсэл ба тэмүүллийг ч гэсэн мөргөл залбирал хэмээн авч үздэг. Чухамдаа Куран сударт, Аллаhad сүсэглэн залбирахын хажуугаар, муу муухайгаас болгоомжлох, элбэг дэлбэг байдал ба зовлон зүдгүүрийн үед бусдад туслах уур хилэнгээ даван туулах, хүмүүсийн бурууг уучлах мөн үйлдсэн нүгэлдээ авталгүйгээр Аллахаас буюу Бурхан тэнгэрээс уучлал гуйх гэх мэт сайн сайхан шинж чанар нь хүнийг диваажинд аваачна гэж заасан байдаг.²⁹

Иман буюу сүсэг бишрэл мөргөл залбирлын салшгүй ба татгалзашгүй төгс болгодог зүйл нь ёс суртахуун юм. Мусульман, итгэж сүсэглэхгүйгээр диваажинд орж чадахгүйгээ, сүсэг бишрэлээ сайн үйлүүд ба сайн төлөвшлөөр чимэхээс нааш төгс нэгэн мүмин болж чадахгүйгээ мэддэг. Учир нь Гэгээн элч (с.а.у), мөргөл залбирал үйлдсэн ч ёс суртахуунтай болж чадаагүй орчин тойрондоо хүндрэл

29 Али Имран, 3/132-136.

учруулсан хүнийг, “дампуурсан” буюу бүхий л мөргөл залбирал сайн үйлүүд нь хий дэмий хоосон зүйл болсон нэгэн хэмээн мэдэгдсэн.³⁰ Бидний Гэгээн элчийн ёс суртахууны өмнө диваажинг баталгаа болгосон энэхүү үгс чухал ач холбогдолтой: *“Та нар надад өөрсдийн талаарх зургаан зүйлд баталгаа гаргаж өгөгтүн, би ч гэсэн та нарт диваажинг баталгаа болгож өгье: Үг яриандаа үнэнийг хэлэгтүн. Амласан бол амлалтаа заавал биелүүлэгтүн. Танд ямар нэгэн даатгасан зүйлийг эзэнд нь хүлээлгэж өгөгтүн. Нэр хүндээ хамгаалагтун. Харам зүйл рүү харахаас зайлсхий. Муу муухайгаас гараа татагтун”*.³¹

Мусульман хүн, диваажинд орохын тулд амьдрал руу хайр болон энэрлийн нүдээр хардаг. Бүтээлийг Бүтээгчээс нь хамааран энэрэнгүй ханддаг. Уучлагч, хүлээцтэй, даруу төлөв ханддаг. Зүрх шархлуулдаггүй, хэнийг ч эс гомдоодог. Тэр ямар ч амьд амьтанд санаатайгаар хор хөнөөл учруулдаггүй. Эрэгтэй, эмэгтэй, хөгшин, хүүхэд, баян ядуу ялгахгүйгээр бүх хүнд хүндэтгэлтэй ханддаг, үг, үйлдлээрээ хэнийг ч гомдоодоггүй.

Мусульман хүн, хүмүүсийн тусламж үзүүлсэн хугацаанд Рабб эзнийхээ тусламжийг хамтдаа гэдгийг мэдэрдэг ба энэ нь өөрийг нь диваажинд хүргэнэ гэдэгт итгэдэг. Мусульман хүний амьдралд сайн сайхан үйл нь хүмүүсийн хандлагаар тогтдоггүй, харин шан харамжийг нь зөвхөн Аллахаас хүлээн диваажинд хүрэх

30 Муслим, Бирр ба Сыла, 59.

31 Ибн Ханбел, V, 323

хүслээрээ үйлддэг. Чухамдаа Куран-Карим, нэгэн боолыг эсвэл олзлогсдыг эрх чөлөөнд хүргэх нь, нэн шаардлагатай үедээ ч гэсэн хамаатан нь болох нэгэн өнчин ба огт юу ч байхгүй нэгэн ядууг хооллон цатгах нь, сүсэглэн биширдэг болон нэгэндээ тэвчээр ба энэрлийг зөвлөх нь «диваажинд хүргэх замыг хялбаршуулдаг» зүйлүүдээс болох баярт мэдээг дуулгасан.³²

Диваажин, Гэгээн элчийн өгүүлснээр, “зүрх сэтгэл нь ариухан ба цэвэрхэн болох” нэгний орон юм. Таквагийн (Аллах эмээх) эзэн болж Аллахын өмнөх хариуцлагаа мэддэг хүмүүсийн зогсоол нь юм. Шударга шулуун, үнэнч ба тууштай хэн нэгэн, ажилдаа хянамгай шударга хийсэн нэгний очих газар юм. Аллахын элч, энэ талаар ийн айлдсан: *“Үнэнийг битгий орхи! Үнэн шударга нь сайн сайханд, сайн сайхан нь диваажинд хүргэдэг нь гарцаагүй. Хүн үргэлж үнэнийг хэлдэг ба үнэнийг эрэлхийлбээс Аллахын өмнө "сыддык" (мөн чанар ба хэлсэн ярьсан нь нэг байдаг) хэмээн бичигддэг. Худал хуурмагаас болгоомжил! Учир нь худал хуурмаг нь муу зүйл рүү хөтөлдөг. Муу муухай там руу хөтөлдөг. Хүн худал хэлдэг ба худал хуурмагийг эрэлхийлэхээ үргэлжлүүлбээс эцэст нь Аллахын өмнө худалч хэмээн бичигдэх болно.*³³

Диваажин нь мөнхийн юм. Ой ухаанд төсөөлж байгаагүйгээс гайхамшигтай гоё сайхан ба эцэс төгсгөлгүй буян хишиг бий газар юм. Диваажинд

32 Белед, 90/12-17.

33 Муслим, Бирр ба Сыла, 103.

хүрэхийг хүссэн хүн, хязгаартай амьдралаараа хязгааргүй болох диваажинд хүрэхийн төлөө анхаарал болгоомжтой амьдардаг. Амьдралаа огт ашиггүй, хэрэгцээгүй, хоосон зүйлүүдээр дүүргэдэггүй. Амьдралын үнэт хугацаа хөрөнгийг, залуу насныхаа энерги, оюун ухаан, авьяас чадвар, эрүүл мэнд, эд хөрөнгөө дэмий зүйлд зарцуулан, үгүй хийдэггүй.

Мэдээжийн хэрэг, диваажинд очих замд бэрхшээл тулгарах болно. Учир нь энэ Дэлхий ертөнц бол туршилтын ертөнц юм. Харин Мусульманчууд, диваажингийн зорчигсод юм. Түүнийг энэ ариун аяллаас ямар ч бэрхшээл саад болохгүй. Шайтан буюу буг чөтгөрийн шивнээ, эсвэл өөрийнх дуусаж мэддэггүй хүсэл тэмүүлүүд, эргэн тойрон дахь нүгэлд урин дууддаг галын хүрээллүүд нь түүнийг эс зогсоож чадна. Мусульманчууд итгэл сүсэг бишрэлээсээ авдаг хүч чадал, тэсвэр тэвчээрээр тууштай байдлаар үйлдлээ хийдэг. Аллахад итгэн найддаг ба Түний тушаалуудыг даган хорьсон зүйлээс холуур байдаг. Гэгээн элчийн амьдралын хэв маягийг өөртөө үлгэр дуурайл болгодог. Эцэст нь Рабб эзнийхээ зөвшөөрөл ба буян хишгээр хязгааргүй орогнол болох диваажинд хүрдэг.

Мусульман, Тамд Оруулах Замуудаас Хол Зогсдог



*“Хэн нэгэн Аллахын зөв шулуун зам өөрт
нь тодорхой болсны дараа гэгээн элчийг
эсэргүүцэн, үнэн сүсэгтнүүдийн замаас өөр
замыг сонговол Бид түүнийг тэр чигээр
нь орхин, халуун там руу оруулах болно.*

Там юутай муухай газар гээч?”³⁴

(Куран- Карим)

Исламын онцгойлох зүйлгүй бүхий л тушаалууд хүн төрөлхтний тусын тулд, бүхий л хоригууд хүн төрөлхтөнд хор хөнөөл учруулах сэдвүүдийг хөнддөг. Исламын хориглосон бодол, үг болон үйлдлийн эхэнд, ширк (Аллах ба Бурхан тэнгэрийг бусад зүйлүүдтэй зүйрлэх) байдаг. Ширк, Аллахаас өөр бурхадтай адилтгах, Түүнээс өөр бурхан тэнгэр бий хэмээн хүлээн зөвшөөрөх, олон бурхадтай нэгэн сүсэг бишрэлийн системийг бий болгохыг хэлнэ. Куфур гэдэг нь, Бүтээгч эзэндээ сүсэглэн итгэхгүй, Бурхан Тэнгэрийг эс хүлээн зөвшөөрөх

34 Ниса, 4/115.

юм. Ширк ч гэсэн куфур ч гэсэн хүнийг там руу чирдэг замуудын эхэнд байрладаг.

Итгэн сүсэглэдэг мөртөө Аллахын тавьсан хил хязгаарыг давах, нүглийг эс тоох, нээлттэйгээр нүгэл үйлдэх болон нүглийн сурталчилгаа рекламыг хийхээс эс татгалзах, нүгэл үйлдсэнийхээ дараа харамсахгүй байх, товчхондоо нүгэл гэдэг зүйлийг эс тоох нь Исламын зүгээс хориглосон.

Исламын шашинд «харам» гэж нэрлэгдэх маш тодорхой хоригууд, Куран судрын айлдварууд ба Гэгээн элч с.а.у-ын хадисуудаар тодорхойлогдсон байдаг. Энэ хоригуудыг үйлдсэнээрээ харамсан залбирч таубе нүглээ наманчлан өршөөл эрэхгүйгээр мөн Аллахын зүгээс өршөөгдөөгүй бол тамаар шийтгэгдэн гэдгийг сануулан хэлсэн байдаг. Энэхүү хөндөгдөж буй хоригуудын ба томоохон нүглүүдийг дарааллуулан авч үзвэл:

- Аллахад сүсэглэн итгэхгүй эсвэл түүнээс өөр Бурхан тэнгэрийг хүлээн зөвшөөрөх.
- Аллахын халдашгүй дархан хэмээх амийг таслах.
- Амиа хорлох ба унтуулах замаар өөрийгөө үхэлд хүргэх.
- Архи болон мансууруулах төрлийн зүйл хэрэглэх.
- Мөрийтэй тоглох.
- Мөнгөний хүүг идэх.
- Хулгай хийх.
- Шударга бус, хууль бус ашиг орлого олох.
- Хэмжих, жинлэх үед залилан хууран мэхлэх.

- Садар самуун, гэр бүлээс гадуур бэлгийн харьцаанд орох.
- Гэмгүй хүнийг завхайрлаа хэмээн гүтгэх.
- Өнчин нэгний хөрөнгийг завших.
- Хувь хүний эрхэнд халдах ба нийтийн эрх ашигт халдах.
- Хүмүүсийн дунд яс хаях.
- Бүх амьд амьтанд дарангуйлал үзүүлэх.
- Эцэг эхийн эрхийг зөрчих ба хүндлэхгүй байх.
- Хөршийнхөө амгалан тайван байдлыг алдагдуулах.
- Эд хөрөнгөө, цаг хугацаагаа, эрүүл мэнддээ хор учруулах.

Эрэгтэй эмэгтэй Мадинагаас болох мусульманчууд Гэгээн элчид анх удаа сүсэглэн бишрэхдээ дараах асуудлууд дээр түүнд энэхүү амлалтыг өгсөн: Аллаһыг ямар нэгэн зүйлтэй адилтгах, хулгай хийхгүй байх, садар самуунд орооцолдохгүй байх, хүүхдүүдээ үхүүлэхгүй байх, Аллаһын болгосон амийг таслахгүй байх, бусдыг гүтгэхгүй байх ба өөрт нь илүү ашигтай зүйлд Гэгээн элчтэй тэрсэлдэхгүй байхыг хэлнэ.³⁵ Тийм учраас эдгээр зарчмууд нь, юуны түрүүнд хүмүүсийг муу муухайгаас хамгаалдаг ба тамаас хамгаалдаг гэж хэлж болно.

Чухамдаа там мэт муухай төгсгөлийг бэлддэг үйлдлүүдийн ихэнх нь сүсэг бишрэлгүй ба ёс суртахуунгүй байдлаас шалтгаалан гардаг. Тийм учраас гайхуулах ба хоёр нүүр гаргах,

35 Мумтэхинэ, 60/12, Бухари, Дият, 2.

ихэмсэг байдал ба бардамнал, атаа жөтөө болон атаархуу байдал, харамч болон сайн сайхныг саатуулах гэх мэт хандлага нь шийтгэл ба тарчлалыг шаарддаг хэмээн Ислам шашинд заасан байдаг.

Мусульман хүн, гар хөлдөө эзэн болсноор хүчирхийлэл, хулгай, дээрэм тонуул зэрэг гараар үйлдэгддэг гэмт хэргээс хол байх үүрэгтэй. Хэл яриагаа хамгаалснаар хов зөөх, бусдыг гүтгэх, хошуу өргөх, худал ярих, худал газарт андгай тангараг өргөх зэрэг хэл ярианаас гарах алдаануудыг үйлдэхгүй байх үүрэгтэй. Үүний зэрэгцээ бэлхүүсээ хамгаалснаар буюу садар самуунаас хол байж цэвэр ариун нэгэн амьдралаар амьдрах үүрэгтэй.

Гэгээн элч (с.а.у) нэгэн хадистээ ийн хэлсэн: *“Там хүний хүссэн зүйлүүдээр, диваажин хүний хүсээгүй зүйлүүдээр хүрээлэгдсэн.”*³⁶ Тийм учраас хүн өөрийнхөө төлөө тамаас хол, тайван амгалан нэгэн хойд ертөнцийн амьдрал руу ба хязгааргүй аврал руу явах зам нь, иман (сүсэг бишрэл), тэвчээр, тэсвэр хатуужил, оюун ухаан, алсын хараа, эрхэм чанар ба найдвар найдлагаас үүдэлтэй.

36 Бухари, Рикак, 28.